



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЖИЛИЙН ТАЙЛАН

2022



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

2021

ЖИЛИЙН ТАЙЛАН
2022



ГАРЧИГ

АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ

Ардчиллын институцийг бэхжүүлэх хөтөлбөр.....	8
Хүний эрхийн хэрэгжилтийг дэмжих хөтөлбөр.....	14
Иргэний нийгмийн орон зайг дэмжих хөтөлбөр.....	21

ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөр.....	30
Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг дэмжих	35

НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөр.....	42
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих хөтөлбөр	51

САНХҮҮГИЙН ТАЙЛАН63

ӨМНӨХ ҮГ

Бидний үйл ажиллагааны гол зорилго нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад иргэд, иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих, чанартай мэдээлэл, судалгаанд үндэслэсэн бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх билээ. Энэхүү зорилгын хүрээнд ардчилсан сайн засаглал, эрх зүйн шинэтгэлийн бодлогын тулгамдсан асуудлуудыг иргэний нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн судлаачидтай хамтран судлах, шинжилгээ, мониторинг хийн үр дүнг бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэх зэргээр улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулахыг зорьж ирлээ.

2022 он ардчилсан сайн засаглалын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чухал он байв. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт (2019)-ийг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай зохицуулалтуудыг холбогдох хууль тогтоомжид суулгах, хэрэгжүүлэх, шинээр хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэж батлах үйл явц өрнөлөө. Нээлттэй нийгэм форум (ННФ) энэхүү үйл явцад өөрийн хувь нэмэр оруулахыг хичээн ажиллалаа. Үүнээс зарим үйл ажиллагааг энд онцлон дурдахад таатай байна.

2008 оноос хэрэгжүүлж эхэлсэн Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийнхөө хүрээнд шүүхийн шинэтгэлийн үр нөлөөг тогтмол үнэлэх, гарч буй ахиц дэвшил, үхралтыг тодорхойлох зорилгоор Шүүхийн индексийн судалгааны анхны тайланг 2021 оны байдлаар гаргаж олон нийтэд танилцууллаа. Шүүхийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг эрдэмтдийн төлөөлөлтэй зөвлөлдөн, олон улсын түршлага, арга

зүйг судалсны үр дүнд үндэсний хэмжээний индекс тодорхойлох арга зүйг боловсруулж, олон нийтийн болон салбарын мэргэжилтнүүдийн санал бодол, захиргааны өгөгдөл, мэдээлэлд суурилсан зургаан үндсэн хэмжигдэхүүнээр шүүхийн өнөөгийн байдлыг үнэлсэн болно.

Шүүхийн тухай шинэ хуулийн дагуу шүүгчийн сахилгын маргааныг бүртгэх, гомдол шалгах гишүүнийг санамсаргүй тохиолдлын журмаар сонгох, маргаан шийдвэрлэх хугацаа тооцох, холбогдох шийдвэрийг цаг тухайд нь бүртгэх, мэдээлэх зэрэг функц бүхий бие даасан систем хөгжүүлэх, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүллээ. Энэхүү систем нь шүүгчид хамаарах сахилгын гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг хараат бус, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ хэмээн найдаж байна.

Үндсэн хуульд туссан улс төрийн намын шинэчлэлтэй холбоотой нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Улсын Их Хурал (УИХ)-аас улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн төслийг боловсруулах ажил үргэлжилж байна. ННФ-ын зүгээс энэ үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэн хуулийн ажлын хэсэгт оролцохоос гадна олон улсын байгууллагууд болон дотоодын эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран шаардлагатай судалгаа хийх, зөвлөмж өгөх, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр оролцогч талуудад мэдээлэл өгөх, маргаантай зарим асуудлаар зөвшилцөл бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлээ.

УИХ-аас 2021 онд шинээр баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны тавдугаар сарын нэгнээс үйлчилж эхэлсэнтэй холбоотой уг хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх, хуулийн хүрээнд нээлттэй өгөгдлийн зарчим, стандартыг боловсруулах асуудлаар иргэний нийгмийн болон төрийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж хамтран ажиллав. Авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэхэд нээлттэй өгөгдлийг ашиглах боломжийг таниулах зорилгоор жил бүр уламжлал болон зохион байгуулагдаж буй нээлттэй өгөгдлийн үзэсгэлэнг «Дата эрх чөлөө: Дижитал хяналт» сэдвийн хүрээнд Авлигатай тэмцэх газар, Бодлогод залуусын хяналт ТББ болон бусад иргэний нийгмийн оролцогчидтой хамтран зохион байгуулж шүүхийн бие даасан байдал, төрийн байгууллагын шударга байдал, улс төрийн хүрээний авлигын төсөөлөл, УИХ-ын гишүүдийн хөрөнгө, орлогын мэдүүлгээс авсан сонирхолтой тоо баримт, УИХ-ын 2020 оны сонгуулийн хэвлэл мэдээллийн тайланд туссан зардлын мэдээллийг харьцуулсан баримт, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээлүүдээс дэлгэн үзүүлсэн нь олон нийтийн анхааралд хүрэв.

Иргэний нийгмийн орон зайг хамгаалан бэхжүүлэх зорилгын хүрээнд ТББ-ын эрх зүйн өнөөгийн орчны дэвшилтэт талыг хадгалж, улам сайжруулах зорилгоор УИХ-д өргөн баригдаад буй Сангийн эрх зүйн байдлын тухай болон Холбооны эрх зүйн байдлын тухай хуулиудын төсөлд үнэлгээ хийж, олон талыг оролцуулсан хэлэлцүүлгүүд зохион байгуулсны зэрэгцээ иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд таниулахад хүчин чармайлт гаргалаа.

Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр нь энэ онд цар тахлын улмаас хүний эрхийн хүрээнд тулгарч буй сорилтыг даван туулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг

үнэлэхэд гол анхаарлаа хандууллаа. “Тайван жагсаал, цуглаан хийх эрх: Тулгамдсан асуудал, шийдэл, гарц”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь зөвшөөрөл, тулгамдсан асуудал”, “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, түүний хэрэгжилтийн байдал”, “Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ”, “Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, хэсгийн хэрэгжилт”, “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт”, “Кибер гэмт хэргийн зохицуулалтын харьцуулсан судалгаа” зэрэг судалгааны ажлыг олон нийтийн хүртээл болгосон нь тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхэд нааштай нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Хохирол барагдуулах үндэсний тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх нь эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн чухал зорилт болж байна. Өнгөрсөн онд зохион байгуулсан “Хохиролгүй барагдууля” хэмээх цахим аяныг хохирол барагдуулах тогтолцоог бэхжүүлэх жишиг тогтоох зорилго бүхий стратегийн өмгөөллийг дэмжих үйл ажиллагаагаар үргэлжлүүлэн тэлж “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх”, “Ковид-19 цар тахлын үед захиргааны хууль бус шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг барагдуулах”, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах жишиг тогтоох” зэрэг сэдвээр стратегийн өмгөөллийн тэтгэлэг олголоо. Тэрчлэн Монголын Криминологичдын Холбоотой хамтран гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцооны харьцуулсан судалгааг хийлээ. Эдгээр үйл ажиллагаа нь үндэсний хохирлын тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зохих хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Нийтийн баялгийн үр ашигтай зарцуулалтад бид 2004 оноос эхлэн анхаарч улсын төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэний нийгмийн хяналтыг бий болгоход багагүй хүчин чармайлт тавьж

ажилласан билээ. 2022 онд төсвийн төлөвлөлт, санхүүгийн удирдлагыг сайжруулах үндсэн дээр төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа шинжилгээг дэмжлээ. Тухайлбал, ННФ-ын дэргэдэх Төсвийн Зөвлөл төсөв, санхүүгийн асуудлуудыг хэлэлцэн, бодлогын шинжилгээ хийж, холбогдох хууль, тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн зөвлөмжүүд гаргалаа. Тэрчлэн “Бүс Ба Зам” санаачилгын төслүүд дэх Монгол Улсын оролцоо, нөлөөлөл, Шинэ сэргэлтийн бодлогын төлөвлөлт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө ба төсвийн уялдаа, Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал зэрэг судалгааг хэвлэн нийтэллээ.


Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэх эрх зүйн шинэчлэл ид өрнөж байна. Энэ удаагийн шинэчлэл нь тогтвортой хөгжлийн зарчмыг нутагшуулан орон нутгийн харилцааг шинэ түвшинд гаргаж, зогсонги байдалд ороод байгаа эрэл хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, аж үйлдвэржилтийг дэмжиж нэмүү өртөг бий болгох, авлига, ашиг сонирхлын эрсдэлийг хязгаарлах зэрэг энэ салбарт тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх томоохон сорилттой тулгарч байна. Энэ хүрээнд хэлэлцэгдэж буй Газрын багц хуулийн төслийг орон нутгийн иргэдэд танилцуулан ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг төлөвлөх, нийтийн хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үйл ажиллагаанд тэдний оролцоог бодитойгоор хангахад чиглэсэн санал шүүмж гаргалаа. Тэрчлэн төрийн өмчийг олон нийтийн хяналт дор зүй зохистойгоор ашиглах, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн саналуудыг боловсруулж, Үндэсний баялгийн

сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслүүдэд тусгуулахаар холбогдох талуудад хүргэлээ.

Олон улсад авлигатай тэмцэх, үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн төрд итгэх итгэлийг дээшлүүлэхэд төрийн мэдээллийн нээлттэй өгөгдлийн сангууд чухал үүрэг гүйцэтгэж байна. ННФ нь Хөгжлийн төлөө өгөгдөл ТББ-тай хамтран төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авалтын үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлийг хянах өгөгдлийн сан, хяналтын хэрэгслийг хөгжүүлж, улмаар улс төрийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлийн үр дагаврыг хөндсөн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээлүүдийг олны хүртээл болгов.

ННФ нь нийтийн эрх ашгийг хамгаалах үр нөлөөтэй хэрэгсэл болох стратегийн өмгөөллийг иргэний нийгмийн байгууллагууд хариуцлага нэхэх үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд нь олон жилийн туршид дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд 2022 онд хэрэгжсэн төслүүдийн үр дүнд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх журам батлагдаж, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд Усны тухай хуулийг хэрэгжүүлэх заалт тусгагдаж, тусгай хамгаалалттай газар нутагт олгосон газрын зөвшөөрлийн мэдээллийг ил тод болгох шийдвэрийг шүүх гаргасан байна.

Ийнхүү бид 2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа товчлон багцалж Танд хүргэж байна. Тайлантай холбоотой санал бодлоо хуваалцах аваас бид нэн талархан хүлээн авах болно.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  (П.Эрдэнэжаргал)



АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ

АРДЧИЛЛЫН ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Ардчилсан тогтолцоо урт хугацаанд оршин тогтнож, хөгжин төлөвшихөд нэг талаас иргэдийн итгэлийг хүлээсэн бат бэх суурьтай ардчиллын институциуд, нөгөө талаас иргэний нийгмийн идэвхтэй оролцоо чухал бөгөөд эдгээр нь харилцан хамааралтай хүчин зүйлс билээ.

Нээлттэй Нийгэм Форумын үйл ажиллагааны стратегид дэвшүүлсэн ерөнхий зорилтын нэг нь ардчиллын институцийг бэхжүүлэхэд чиглэж байна. Энэ хүрээнд бид улс төрийн намын санхүүжилт, сонгуулийн үйл явц, төрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, энэ асуудлаарх гол хуулиудын хэрэгжилтийг иргэний нийгмийн оролцоотой эрчимжүүлэхэд анхааран ажиллаж ирлээ.

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТ, ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Үндсэн хуульд туссан улс төрийн намын шинэчлэлтэй холбоотой нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Улсын Их Хурал (УИХ)-аас улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн төслийг боловсруулах ажил үргэлжилж байна. ННФ-ын зүгээс энэ үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэн хуулийн ажлын хэсэгт оролцохоос гадна олон улсын байгууллагууд болон дотоодын эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран шаардлагатай судалгаа хийх, зөвлөмж өгөх, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр оролцогч талуудад мэдээлэл өгөх, маргаантай зарим асуудлаар зөвшилцөл бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүллээ.



Нээлттэй өгөгдлийг ашиглан ил тод байдал, хариуцлагыг сайжруулах боломжийг олон нийтэд сурталчлах, энэ чиглэлээр иргэний нийгмийн байгууллагууд, эрэн сурважлагч сэтгүүлчдийн хийж буй ажлыг танилцуулах зорилго бүхий Нээлттэй өгөгдөл-Дижитал хяналт үзэсгэлэнгийн үеэр.

Дээрх хуулийн төсөлд туссан нааштай өөрчлөлтүүдийн талаар олон нийтэд болон бусад оролцогч талд мэдээлэл өгөх, ойлголтыг гүнзгийрүүлэх, намууд болон бодлого боловсруулагчдын зүгээс эргэлзэж буй асуултуудад хариулт хайх, шийдлийг боловсруулж тодруулах “Бодлого ярьцагая” цуврал хэлэлцүүлгийг Бодлогод залуусын хяналт ТББ- тай хамтран зохион байгуулав. 2022 оны 4-5 сард болсон нээлттэй хэлэлцүүлгүүдэд 80 орчим оролцогч оролцож “Эвлэлдэн нэгдэх эрх ба улс төрийн намын хатуу гишүүнчлэл,” “Бодлогын намыг төлөвшүүлэх нь,” “Улс төрийн намд төрөөс санхүүжилт олгох зарчим, шалгуур,” “Улс төрийн намын дотоод ардчилал,” “Улс төрийн намын санхүүжилт, үйл ажиллагаанд тавих хяналт болон намын бүтэц зохион байгуулалт” сэдвүүдээр улс төр судлаач эрдэмтдээс мэдээлэл сонсон асуулт асууж, ярилцав.

Түүнчлэн эдгээр асуудлаар мэдээлэл өгөх, улс төрийн намын хуулийн асуудлаар мэдээ сурвалжилга бэлтгэхэд туршлагатай сэтгүүлчдээс суралцах боломж олгох зорилго бүхий 3 цуврал хэлэлцүүлгийг 11-р сард сэтгүүлчдийн дунд зохион байгууллаа.

УИХ-ын даргаас Европын Зөвлөлийн Венецийн комисст хандан Улс төрийн намын тухай хуульд олон улсын мэргэжилтнүүдийн санал зөвлөмж авах хүсэлт гаргасан дагуу 2022 оны 5-р сард Венецийн комиссын мэргэжилтнүүдийг дотоодын оролцогч талуудтай санал солилцон мэдээлэл авахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллав. Тус байгууллагаас хуулийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг 2022 оны 6-р сард олон нийтэд танилцууллаа.¹

¹ Венецийн комисс, ЕАБХАБ-ын Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн төсөлд өгсөн хамтарсан дүгнэлт зөвлөмж. 2022. <[https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2022\)022-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2022)022-e)>



Улс төр судлаач эрдэмтэн О.Гэрэлт-Од хэлэлцүүлгийн зочноор уригдан “Улс төрийн намд төрөөс санхүүжилт олгох зарчим, шалгуур” сэдвээр ярилцаж байгаа нь.

СОНГУУЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭЧЛЭЛ

Сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгохтой холбоотой өмнөх сонгуулиудаар маргаан дагуулж, анхаарал татсан асуудлын нэг болох сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, ил тод байдлыг хангах, хяналт тавих асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар МИДАС ТББ тэргүүтэй Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллагууд, Сонгуулийн ерөнхий хороо, Тагнуулын ерөнхий газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулан семинар зохион байгуулж үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулан оролцогч талуудад танилцуулав.

Түүнчлэн сонгуулийн төв байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх болон санал худалдан авахтай

холбоотой зөрчлийг хянан шийдвэрлэх процессыг судлах чиглэлээр Баристос Кастос хуулийн фирм, Оюуны инноваци ТББ болон бусад хуульч, судлаачтай хамтран ажиллаж байна. 2023 онд Парламент ард түмнийг төлөөлөх институци болохын хувьд үйл ажиллагааг нь үнэлэхэд чухал ач холбогдолтой өгөгдлийн сан хөгжүүлж буй Цогц хөгжлийн төлөө төвд тэтгэлгийн дэмжлэг үзүүлж УИХ-ын хүралдааны дэгийн тухай хууль, УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгөгдлийн санг баяжуулах, УИХ-дээр явагдаж буй сонголчуудын талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, олон нийтэд зориулсан контент бэлтгэн хүргэхэд хамтран ажиллалаа.

ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

УИХ-аас 2021 онд шинээр баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны тавдугаар сарын нэгнээс үйлчилж эхэлсэнтэй холбоотой үг хуулийн хэрэгжилтэд мониторинг хийж мэдээлэл хариуцагчид мэдээллийн ил тод байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргээ ямар түвшинд гүйцэтгэж байгаа талаар баримт цуглуулж, үнэлгээ хийхэд Глоб Интернэшнл ТББ-д дэмжлэг үзүүлэв. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд төрийн нээлттэй өгөгдлийн талаар анх удаа нарийвчлан тусгасантай холбоотой нээлттэй өгөгдлийн шалгуур зарчим, стандарт, хэрэглээний

талаар оролцогч талуудад мэдээлэл өгөх, авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэхэд нээлттэй өгөгдлийг ашиглах боломжийн талаар иргэний нийгэмд сурталчилж таниулах ажлыг Тунгаахуй өгөгдлийн урлан, Бодлогод залуусын хяналт ТББ-уудтай хамтран жилийн турш шат дараатай зохион байгуулав. Энэ санаачилгын хүрээнд жил бүрийн 12-р сарын 9-нд тохиодог Олон улсын авлигатай тэмцэх өдрийг угтан Авлигатай тэмцэх газар болон дээрх иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран “Дата эрх чөлөө: Дижитал хяналт” үзэсгэлэнг 2022 оны 12-р сарын 5-8-ны өдрүүдэд зохион байгууллаа.



Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх асуудлаар судалгаа хийхийн зэрэгцээ тал талын байр сүүрийг сонсох, хэлэлцэх үүлзалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

Чөлөөт, шударга сонгуулийг Ардчилсан сонгуулийн зарчимд нийцүүлэн хуулийн хүрээнд зохион байгуулахад хараат бус, бие даасан, мэргэжлийн, чадварлаг сонгуулийн удирдлагын байгууллага чухал үүрэг гүйцэтгэдэг.

Сонгуулийн удирдлагын байгууллагын бүрэлдэхүүнтэй холбоотой олон улсын туршлагыг авч үзэхэд 1. Олон намын төлөөллөөс бүрдсэн, 2. Мэргэжлийн экспертүүдээс бүрдсэн, 3. Намын төлөөлөл болон мэргэжлийн экспертүүдээс бүрдсэн холимог гишүүд бүхий сонгуулийн удирдлагын байгууллагын загварууд байна. Судлаачийн хувьд сонгуулийн удирдлагын байгууллагын холимог гишүүнчлэл бүхий бүрэлдэхүүний загвар нь улс төрийн хувьд харилцан хяналттай байдлыг мэргэжлийн хараат бус үр чадвартай хослуулснаар тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, мэргэжилтнүүд болон улс төрийн намын төлөөлөл хоорондын харилцан итгэлцэл нь улс төрийн хувьд төвийг сахисан, мэргэжлийн шийдвэр гаргахад дөхөмтэй зэрэг давуу талтай тул Монгол Улсад тохиромжтой гэсэн байр сүүртэй байдаг. Ийм загварыг сонгосон тохиолдолд сонгуулийн удирдлагын байгууллага нь улс төрийн болон олон нийтийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарах нь харьцангуй бага байгааг судалгаа харуулдаг.

Хуульч, судлаач Д. Бат-Эрдэнэ



2022 оны 10 сарын 2-9-ний өдрүүдэд Дундговь, Өмнөговь аймгуудад зохион байгуулсан Төрийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн оролцоо сургалтын үеэр.



Нээлттэй өгөгдөл-Дижитал хяналт үзэсгэлэнгийн үеэр Бодлогод залуусын хяналт ТББ-аас 2020, 2021 оны сонгуулиудын зардалд мониторинг хийсэн дүнг танилцуулав.

Үзэсгэлэнд шүүхийн бие даасан байдал, төрийн байгууллагын шударга байдал, улс төрийн хүрээний авлигын төсөөлөл, УИХ-ын гишүүдийн хөрөнгө, орлогын мэдүүлгээс авсан сонирхолтой тоо баримт, УИХ-ын 2020 оны сонгуулийн хэвлэл мэдээллийн тайланд туссан зардлын мэдээллийг харьцуулсан баримт, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээлүүдээс дэлгэн үзүүлэхийн сацуу үзэсгэлэнгийн үеэр сургалт, хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулав.

ННФ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Төрийн ил тод хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн оролцоо” сэдэвт сургалтыг Өмнөговь, Дундговь аймгуудад зохион байгуулав. Хөдөөд үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын 60 гаруй төлөөлөл оролцсон сургалтын хүрээнд төсвийн үйл явцад мониторинг хийх арга зүй, нийтийн эрх ашгийн өмгөөлөл, нээлттэй сонсгол гэх мэт арга хэрэгслийн талаар танилцуулснаас гадна

анх удаа цахим орчин дахь аюулгүй байдал сэдвээр мэдээллийн боловсрол олгоход чиглэсэн агуулга боловсруулж хүргэлээ.

Иргэдийн оролцооны чухал арга зам болох төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх иргэний эрхтэй холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг шинэчлэх үйл явцад судалгаа шинжилгээгээр дэмжлэг үзүүлж, иргэний нийгмийн болон бодлого боловсруулагчдад судалгааны үр дүнг танилцуулж хэлэлцүүлэх ажлыг зохион байгууллаа. Энэхүү чухал сэдвийн хүрээнд “Оюуны-Инноваци” ТББ-тай хамтран 2022 оны зургаадугаар сарын 07-нд уулзалт-хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Хууль зүйн доктор (Dr.Jur) Д.Сүнжид “Иргэний өргөдөл, гомдол гаргах эрхийн баталгаа –Иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэх процесс, практик үүсэж буй асуудал”, “Оюуны-Инноваци” ТББ-ын судлаач Б.Төрболд

“Захиргааны ерөнхий хуулийн шинэчлэлийн хүрээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үйл явцыг боловсронгуй болгох асуудал” сэдэвт илтгэлүүдийг танилцуулж, хэлэлцүүлэгт оролцсон төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл санал солилцов.

Нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх иргэний нийгмийн санаачилгыг дэмжиж Амьд хууль төв ТББ, Фиделитас партнерс ХХН, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо тэргүүтэй байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломжийг хангах, КОВИД-19 цар тахлын үеийн хандив тусламжийн зарцуулалтын ил тод байдлыг хангах, тусгай хамгаалалттай газар нутагт амьдардаг мал бүхий иргэдийн эрх ашгийг хамгаалах гэх мэт асуудлаар ажиллахад дэмжлэг үзүүлэв.

Орон нутагт нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах чадавх бүрдүүлэх зорилготой тэтгэлгийн хүрээнд Амьд хууль ТББ нь Баянхонгор аймгийн хэмжээнд нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагаанд хяналт тавьж, нийтийн өмчийн удирдлага, зарцуулалттай холбоотой зөрчлүүдийг арилгуулахаар ажиллаж байна. Энэ чиглэлээр төрийн байгууллагуудын дунд цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагааны улмаас төрд учирсан хохирлыг барагдуулахад аймгийн аудит, прокурорын байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна Баянхонгор аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд газар ашиглуулах шийдвэр, тендерийн үйл ажиллагаанд иргэний

нийгмийн хяналтыг бий болгох ажлыг түсгүүлжээ. Тэрчлэн Шинэжинст суманд олгогдсон Эрдэнэ Монгол ХХК-ийн алт олборлох тусгай зөвшөөрлийн хууль ёсны байдлыг шалгуулах, тус компанийн Баянхонгор аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг илт хууль бусад тооцуулах нэхэмжлэлүүдийг захиргааны хэргийн шүүхэд гарган ажиллаж байна.

Феделитас Партнерс ХХН-аас гаргасан гомдлын мөрөөр Үндэсний аудитын газраас Сангийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн онцгой байдлын газар, Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ковид-19 цар тахлын үеийн хандив тусламжийн зарцуулалтын ил тод байдалд нийцлийн аудит хийж, зөвлөмж хүргүүлэв. Энэ онд дээр дурдагдсан байгууллагууд аудитын зөвлөмжийг хэрэгжүүлснээр Сангийн яам нь цар тахлын үед Засгийн газраас эдийн засгийг эрчимжүүлэх, ажлын байрыг хадгалах, иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний болон гадаадын зээл тусламжийн зарцуулалтын мэдээллийг Иргэдийн төсвийн цахим хуудаст байршуулж, Шилэн дансны нэгдсэн системд цар тахалтай холбоотой хандив тусламжийн орлого, зарлагыг мэдээлэх цэс шинээр үүсгэжээ. Ингэснээр төрийн байгууллагууд мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан орлого, зарлагыг шилэн дансанд тусгайлан байршуулах боломж бүрдэж, Нийслэлийн онцгой байдлын газар нь 30.5 сая төгрөгийн хандивын орлого, 20.5 сая төгрөгийн зарлагыг, Онцгой байдлын ерөнхий газар нь бараа материалаар хүлээн авсан хандивыг, Халдварт өвчин судлалын үндэсний төв нь 18 сая төгрөгийн орлого, 36.5 сая төгрөгийн зарцуулалтын мэдээллийг нээлттэй болгосон байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Хүн бүхэнд угаас заяасан ... адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн гэдгийг иш үндэс болгон;

хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны ариун сэтгэлийг сэвтээн, жигшм балмад үйлдэлд хүргэж байсан бөгөөд хүмүүс үгээ хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй, айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн хэмээн үзэж;

хүмүүс эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд хүний эрхийг хуулиар хамгаалах нь нэн чухал гэдгийг анхааран;

... хувь хүн нэр төр, үнэ цэнэтэй, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй гэдэгт Нэгдсэн Үндэстний улс түмэн бүрэн итгэж байгаагаа дүрмээрээ нотлохын хамт, илүү эрх чөлөөтэй байдал, амьдралын илүү таатай нөхцөлд чиглэсэн нийгмийн дэвшилд тэмүүлэхээр нийт гишүүн улсууд шийдвэрлэснийг харгалзан;

... энэхүү хүний эрхийн түгээмэл тунхаглалыг ... зарлан тунхаглаж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 1948 оны 12 сарын 10

Нээлттэй нийгэм форум нь бусад иргэний нийгмийн байгуулагатай хамтран Монгол Улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах, иргэдийн хүний эрхийн боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулахыг зорьж ажилладаг билээ. Энэ онд “Ковид-19” цар тахлын эдийн засаг, хүмүүсийн амьжиргаанд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, ар араасаа цацагдсан авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээ зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан иргэд үзэл бодлоо илэрхийлэх, жагсах цуглах давтамж өсөж, үүнтэй зэрэгцээд иргэний, улс төрийн эрх зөрчигдөх, эрхийг хууль бусаар хязгаарлах зэрэг олон сорилт тулгарлаа. Иймээс хүний эрхийн салбарт гарч болзошгүй үхралтаас сэргийлэх, өмнөх ололтоо бататган бэхжүүлэх нь хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын өмнө тулгамдсан нэн чухал зорилт байв.



Сүхбаатарын талбайд өрнөсөн олон нийтийн жагсаал, 2022 оны 12 сар

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд эрх зүйн орчин нэн чухал бөгөөд 2020 оны Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг, 2021 оны Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоог тус тус ХЭҮК-ын дэргэд байгуулахаар зохицуулсан билээ.

Дээрх эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Хүний эрхийг хамгаалах тогтолцоонд голлох үүрэг бүхий Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүдийг УИХ-аас томилохдоо анх удаа нээлттэй сонгон шалгаруулж томилгооны сонсгол хийлээ. 2016 оноос хэрэгжиж эхэлсэн Нийтийн сонсголын тухай хуульд нээлттэй сонсголын есөн төрлийг хуульчилсны нэг нь нэр

дэвшигчийн сонсгол юм. ХЭҮК-ын гишүүдийг томилох сонсгол нь уг хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш анх удаа зохион байгуулсан сонсгол байв. Иймд ННФ-аас хуулийн хүрээнд холбогдох журмыг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажилласны зэрэгцээ, сонгон шалгаруулах ажлын хэсэгт иргэний нийгмийн идэвхтэй оролцоог хангахад анхаарч ажиллав.

ХЭҮК-ын гишүүдийг томилох сонсгол нь дараа дараагийн сонсголыг иргэдийн оролцоотой, ил тод нээлттэй зохион байгуулахад жишиг болохуйц, үр дүнтэй, зохион байгуулалт сайтай сонсгол болсныг хүний эрхийн байгууллагууд, судлаачид болон ажлын хэсгийн зарим гишүүн дүгнэсэн байдаг. Томилгооны сонсгол нь хараат бус институтийн бие даасан бэхжүүлэхэд туйлын чухал ач холбогдолтой юм.



Шинээр бий болж буй эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бэхжүүлэх, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулсан “Эрүүгийн процесс ба Хүний эрх” цуврал хэлэлцүүлгийн үеэр “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” сэдвээр хэлэлцэж, тэмдэглэлийг эмхэтгэн олон нийтэд хүргэлээ.

Мөн тус механизмын төсвийн хараат бус байдал хэрхэн зохицуулагдсаныг судлах зорилгоор төсвийн хууль тогтоомж болон Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг харьцуулан шинжилж, цаашдын гарцыг эрэлхийлэх уулзалтыг ХЭҮК-ын гишүүд болон Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, холбогдох албан тушаалтныг оролцуулан зохион байгууллаа.

Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн шинээр томилогдсонтой холбогдуулан хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу хэд хэдэн журам батлах юм. Энэ хүрээнд зарим эрх зүйн актын төсөлд ХЭФ-аас санал өгч оролцсоны зэрэгцээ тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, дүгнэлт гаргах журам боловсруулах, эрсдэлд өртөж буй хүний эрх хамгаалагчийг тус механизмтай холбон зуучлах ажлыг зохион байгуулсан нь энэхүү механизмын үр нөлөөг нэмэгдүүлэхэд түлхэц болсон юм.

Цар тахлын үед хомс төсвөөр ажиллаж буй ХЭҮК-т дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021 онд тэтгэлэг олгосон бөгөөд энэ онд тус тэтгэлгийн хүрээнд сэтгүүлчдийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, төр, иргэн, салбарын мэргэжилтнүүдтэй хүний эрхийн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, ХЭҮК-ын олон нийттэй харилцах ажиллагааг сайжруулах, энэ үйл явцад залуу уран бүтээлчдийг татан оролцуулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулжээ. Тус тэтгэлгийн хүрээнд ХЭҮК хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах стратеги, “Тайван бус жагсаал, цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гамшгаас хамгаалах бэлэн байдал болон онц байдал зарласан үед Хүний эрхийн Үндэсний Комиссын ажиллах журам”, “Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагааны журам” зэрэг баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ НЬ



Эгнээндээ хүний эрхийн чиглэлээр ажилладаг 50 гаруй ТББ-ыг нэгтгэсэн сайн дурын сүлжээ болох Хүний эрхийн форум (ХЭФ) нь 2010 оноос эхлэн эдүгээ 12 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Тус форум нь хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны нэг чухал хэсэг болсон бөгөөд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” механизмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, улмаар сайн түршлага нь олон улсын түвшинд түгээгдсэн билээ. Энэ жил Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг механизмын 3 дахь үе шатны хэлэлцүүлгээс хүлээн авсан 170 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр хүний эрхийн үндэсний тогтолцоо, иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм соёлын эрх, бүлгийн эрх гэсэн сэдвийн хүрээнд ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна.

ХЭФ-ын 10 гаруй жилийн нөлөөллийн ажлын үр дүнд хүний эрхийн тодорхой асуудлаар төр, иргэний нийгмийн байгууллагууд зөвшилцөх соёл тогтож буй бөгөөд энэ онд Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах конвенцын хэрэгжилтийн талаарх ЗГ-ын тайлан, Байгальд зорчих, явган аялах эрхийн тухай, Гэрийн тэжээвэр амьтны тухай зэрэг хуулийн төсөлд ХЭФ-ын зүгээс санал зөвлөмж боловсруулж хүргүүлсэн болно.

Нэгдсэн Үндэстний Байгууллага нь “Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн сахих нь бүх нийтийн аюулгүй байдал, энхтайвны үндэс” болохыг тунхаглаж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэмээх түүхэн чухал баримт бичгийг 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталснаас хойш жил бүрийн энэ өдрийг “Хүний эрхийн өдөр” хэмээн дэлхий нийтээрээ тэмдэглэдэг уламжлал тогтсон билээ. Хүний эрхийн форум нь 2014 оноос эхлэн хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд тайван жагсаал зохион байгуулж ирсэн түршлагатай. 2022 онд “Бид тэвчихгүй” аян цахим хэлбэрээр зохион байгуулж, Хүний эрхийн форумын гишүүд жагсаал, цуглаанд хөндлөнгийн ажиглалт хийх, гарсан зөрчил дутагдлыг холбогдох албаны хүмүүст тухай бүрд сануулах, иргэд, хууль сахиулагчдад хандан мэдээлэл түгээх зэрэгт анхаарч ажиллалаа. Тус ажиглалтын түршлагад тулгуурлан цаашид энэ төрлийн үйл ажиллагааны үеэр хэрхэн ажиллах арга зүйг боловсруулах, мөн ажиглалтын явцад хийсэн баримтжуулалтын тайланг гаргаж олон нийтэд ирэх онд танилцуулахаар төлөвлөвөө.



ХЭТББФ-ын гишүүн Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ-ын ажиглагч нар, 2022 оны 12 сар.
Эх сурвалж: <https://www.facebook.com/women4changemongolia>

Хүний эрхийн форум цахим аяны хүрээнд гишүүн байгууллагын хүний эрхийн чиглэлээр амжилттай ажилласан түүхийг хүргэх замаар иргэний нийгмийн нийгэмд гүйцэтгэж буй үүргийг олон нийтэд танилцуулахыг зорьж, нийт 8 байгууллагын постер түгээгээд байгаа бөгөөд энэ үйл ажиллагааг ирэх онд ч үргэлжлүүлэхээр ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар жагсаал цуглаан хийх, халдашгүй байх эрхийн зөрчил нэмэгдэх болсны зэрэгцээ жагсаал, цуглааны давтамж ч улам бүр өсч байна. Цар тахлын үед жагсаал, цуглаан хийх явцад илтэд тэгш бус хандсан тохиолдол цөөнгүй бүртгэгдсэнийг судалгаа, мониторингийн дүн харуулж байна. Мөн төрийн байгууллагын нэр хүнд хохирсон хэмээн иргэд,

сэтгүүлчдийг шүүхэд дуудсан тохиолдол ч мэр сэр гарлаа. Энэ бүхнээс дүгнэхэд хүний эрхийн зөрчил нэмэгдэх хандлагатай, тэр тусмаа хязгаарлахад онцгой нөхцөл тавигддаг, зөрчлийг даруй таслан зогсоох, хохирлыг нэн даруй барагдуулах шинжээрээ ялгардаг иргэний, улс төрийн эрхүүд зөрчигдөх өндөр эрсдэлтэй байгаа нь хүний эрх хамгаалагчдын үүрэг оролцоог улам бүр шаардах боллоо. Энэ нөхцөлд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр ХЭФ-ын гүйцэтгэх үүрэг оролцоо ч өсөн нэмэгдэж байна. ННФ нь 2020 онд хүний эрх зөрчигдөх эрсдэлтэй нөхцөл байдалд яаралтай хариу үйлдэл үзүүлэх тусгай төсвийг Хүний эрхийн форумын дэргэд бүрдүүлсэн бөгөөд энэ жил мөн нэмж тэтгэлэг олголоо.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, МЭДЛЭГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ НЬ

ННФ нь хүний эрхийн боловсрол, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, нийгэмд өрнөж буй "халуун" сэдвийг хүний эрхийн өнцгөөс хэлэлцэх зорилгоор "Хүний эрхийн тухай ярилцъя" сар тутмын цуврал хэлэлцүүлгийг Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран 2013 оноос зохион байгуулж байгаа билээ. Цар тахлын улмаас тус хэлэлцүүлэг цахим хэлбэрт шилжсэн бөгөөд энэ онд цахим, танхим хослуулан явуулсны зэрэгцээ зөвхөн нийслэл хотод төдийгүй орон нутагт зохион байгууллаа. Улаанбаатар хотод болсон хэлэлцүүлгээр өөрсдөд нь тулгамдаж буй асуудлын талаар олон салбарын төлөөлөл болсон залуус хамтран ярилцлаа. Сэлэнгэ, Ховд, Орхон, Дорнод, Өмнөговь аймгийг хамруулан зохион байгуулсан хэлэлцүүлгүүдэд аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нар оролцон, орон нутагт тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг хөндөн, хамгаалах арга замыг эрэлхийллээ.

Бид хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд нэг чухал арга хэрэгсэл бол хүний эрхийн мэргэжилтнүүд мэдлэг туршлагаа хуваалцах олон нийтийн лекц хэмээн үздэг бөгөөд тус үйл ажиллагааг ХЭҮК-той хамтран арав гаруй жил зохион байгуулж байна. Цар тахлын улмаас 2020, 2021 онд завсарлаад байсан тус үйл ажиллагааг хүндэтгэлийн лекц хэлбэрээр үргэлжлүүллээ. Анхны хүндэтгэлийн лекцэд Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Аксель Никэйз оролцож, "Монгол Улс дахь хүний эрх: Эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд анхаарал хандуулах нь" сэдвээр лекц уншлаа. Энэ үеэр НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газрын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын фактын хэрэгжилтийн тайланг хэлэлцээд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг дэлгэрэнгүй танилцуулсан нь онцлох үйл явдал болов.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

ЕВРОПЫН ХОЛБООНЫ МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

"ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ЯРИЛЦЪЯ" ХҮНДЭТГЭЛИЙН ЛЕКЦ 2022

Сэдэв:
МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ-ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХЭД АНХААРАЛ ХАНДУУЛАХ НЬ:

- Монгол Улс ба Хүний эрхийн гэрээнүүд
- Хөнгөлөлтийн ерөнхий систем + ба түүний конвенцүүд
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны ажиглалт, дүгнэлт

Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд
АКСЕЛЬ НИКЭЙЗ

Хүний эрхийн мэдлэгийг тэлэх, тулгамдсан асуудалд шийдвэр гаргагч, олон нийтийн анхаарлыг хандуулахад видео контент чухал ач холбогдолтой хэмээн үзэж, шинэ контентыг баримтад түшиглэсэн, хүний эрхийн онол, практикийн мэдээллийг тусгасан хэлбэрээр бүтээхийг зорьсон юм. Тиймээс энэ чиглэлээр “Шинэ технологийн хүний эрхэд учруулах эрсдэл Монгол Улсад: Бодлого, эрх зүйн орчин, нөхцөл байдал” сэдвээр тандалтын судалгаа хийгээд байгаа бөгөөд ХЭҮК, МҮОНТ-тэй хамтран “Сэтгэцийн эрүүл мэнд ба хүний эрх”, “Технологи ба Хүний эрх”, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал”, “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр”, “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ” зэрэг сэдвээр телевизийн контент бүтээх ажлыг эхлүүлээ. Энэ хүрээнд Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймгийн төв болон зарим сумдын дотуур байрны нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, сэтгэцийн эрүүл мэнд, технологи, хуулийн салбарын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр бодит мэдээлэл, баримтад үндэслэсэн контент бүтээж эхлээд байна.

Дэлхий нийтэд ардчилал, хүний эрхийн асуудал нь томоохон сорилттой тулгараад байгаа өнөө үед иргэдийн ардчилал, хүний эрхийн боловсролыг

дээшлүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Гэвч энэ чиглэлийн үйл ажиллагааны цар хүрээ төдийлөн хангалттай биш, олон нийтийг өргөнөөр хамруулах үйл ажиллагаа өндөр өртөг зардалтай бүтдэг. Харин урлаг, уран сайхны үйл ажиллагаа нь нийтийн анхаарлыг татаж, хүчтэй нөлөө үзүүлдэг хэдий ч эдгээр контентод хүний эрхийн өнцгөөс дүн шинжилгээ хийх, бүх талын оролцоотой хэлэлцүүлэх асуудал орхигдсоор иржээ. Монголын анхны кино “Хуучин хүү” 1936 онд дэлгэцнээ гарснаас хойш 2000 он хүртэл 56 жилийн хугацаанд 292 бүрэн хэмжээний кино буюу жилд дунджаар 5 кино бүтээж байсан бол эдүгээ жилдээ 50 шахам кино бүтээгдэх болжээ. Тиймээс хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг кино шүүмжид нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч ирж буй тул хамгийн олон үзэгчтэй, сүүлийн 3 жилд хийгдсэн бүрэн хэмжээний 10 уран сайхны кинонд шүүмж хийх тэтгэлэг Глоб интернэйшнл төв ТББ-д олголоо. 2021 онд байгуулагдсан Кино урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх кинонд тавигдах чухал шалгуурын нэг нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоох зорилгод чиглэхийн зэрэгцээ, 2-р бүлгийн 16-р зүйлд заасан хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжсэн байх явдал.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Иргэд нь дарамт, хяналтад өртөхөөс эмээхгүй үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэн, шаардлагатай гэж үзсэн үедээ бусад иргэдтэй эвлэлдэн нэгдэж өөрийн болон нийтийн эрх ашиг, сонирхлыг хамгаалан, бухимдал дургүйцлээ тайван жагсаал цуглаанаар илэрхийлэх боломжоор хангагдсан байх нь ардчилсан нийгмийг дарангуйллаас ялгаж өгөх үндсэн шинж болно.

Монгол Улс бол төр нь ардчилсан ёсоор засаглаж (Үндсэн хуулийн 1.2), ард түмэн нь төрийн үйл хэрэгт оролцох (Үндсэн хуулийн 3.1.) эрхтэй ардчилсан улс юм. Дэлхийн хэмжээнд сүүлийн 10 гаруй жилийн турш ардчиллын чанар уруудаж, цөөн хүний эрх мэдлийг бататгасан авторитар засаглал газар авч байгаа энэ цаг үед олон улсын индекс, рейтингээр Монгол Улс иргэд нь эрх чөлөөтэй¹, иргэний нийгэм нь саад тотгортой², системийн гажуудалтай ч ардчилсан улс³ хэвээр байна. Ер нь сүүлийн 30 гаруй жил ийм л байж ирсэн бөгөөд ардчиллын нягтрал явагдахгүй, ардчилал руу шилжих үйл явц үргэлжилсээр байна гэж зарим судлаач дүгнэдэг.

Иргэний оролцоо нь иргэдийн суурь эрх төдийгүй төрд, цаашилбал, ардчилалд итгэх ард олны итгэлийг бэхжүүлэх үр нөлөөтэй хүчин зүйл юм. Гагцхүү, иргэдэд идэвхтэй, үр нөлөөтэй оролцоход төрийн бодлого, шийдвэрийн үндэслэл, шийдвэр гаргах үйл явц ойлгомжтой, нээлттэй, ил тод байх боломжийг хангасан эрх зүйн орчин, тал бүрийн мэдээлэлтэй оролцоход туслах чөлөөт хэвлэл мэдээлэл, мөн хүний эрхэд суурилсан хандлагатай төр, захиргааны үйл ажиллагаа шаардлагатай. Нээлттэй нийгэм форум нь Иргэний оролцооны хөтөлбөрөөр дамжуулан иргэний нийгмийн эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмрээ оруулах, оролцооны сайн түршлага, арга механизмыг сурталчлан таниулах, мөн ардчилсан иргэн байхад тус болох ардчилал, хүний эрхийн боловсролыг түгээх зорилготой ажиллаж байна.

² Фрийдом Хаусын Дэлхийн эрх чөлөөний индекс 2022

³ СИВИКУС-ын Иргэний нийгмийн орон зайн индекс 2022

⁴ Экономист сэтгүүлийн Ардчиллын индекс 2022

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний нэг хэлбэр болох Төрийн бус байгууллагын тухай 1997 оны хуулийг 2002 онд батлагдсан Эрүүгийн хуульд нийцүүлэн өөрчлөх үйл явц 2005 оноос эхэлж ашгийн бус хуулийн этгээдийг зохицуулах олон тооны төсөл хэлэлцэгдэж байв. 2021 оны 11 дүгээр сард ХЗДХЯ-аас өмнөх төслүүдийг нэгтгэн Сангийн эрх зүйн байдлын тухай болон Холбооны эрх зүйн байдлын тухай хоёр хуулийн төсөл УИХ-д өргөн барьсан болно. Төрийн бус байгууллага (ТББ)-уудын зүгээс ХЗДХЯ энэхүү хуулийн төслийг нэгтгэн боловсруулахдаа тэдний оролцоог хангаагүйн дээр үзэл баримтлалын хувьд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих бус харин ТББ-уудыг төрийн хараа хяналтад оруулахад чиглэсэн бүртгэл, хяналт, тайлагналтын зайлшгүй бус шинжтэй шаардлагууд нэмэгдсэнийг шүүмжилж байна. Хуулийн төслүүд нь иргэний нийгмийн салбарт тулгамдаад байгаа асуудлуудыг шийдээгүйн дээр иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хөндөж байна гэсэн шүүмжлэл олон

нийтийн дунд, цаашилбал, УИХ-ын чуулганы танхимд ч өрнөж байна.

ННФ нь энэхүү бодлогын хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах үүднээс Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг өнгөрсөн онд хийлгэсэн билээ. Үнэлгээгээр дээрх хуулийн төслүүдийн Үзэл баримтлалд тусгасан зорилгыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай зарим зохицуулалтыг орхигдуулсан, бүртгэл, тайлагналтыг хүндрүүлсэн, зайлшгүй бус буюу бусад хууль тогтоомжтой давхардсан нэмэлт хяналт, хариуцлагын зүйл заалтыг оруулсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зохицуулалтыг зарим тохиолдолд дордуулсан байх тул зорилгодоо хүрэх, практикт хэрэгжих, ойлгомжтой байх, хүлээн зөвшөөрөгдөх, харилцан уялдаатай байх зэрэг хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг хангаагүй байна гэж дүгнэжээ.



Төр, иргэний нийгэм, дотоод гадаадын судалгааны байгууллагын төлөөлөгчид Сангийн, мөн Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг тал талаас нь хэлэлцэв.

2022 оны 11 сарын 2-нд ХЗДХЯ, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн, ННФ хамтран зохион байгуулсан УИХ-д өргөн баригдаад буй хуулийн төслийн хэлэлцүүлэгт төр болон төрийн бус байгууллагын төлөөлөл, дотоод, гадаадын судлаач 100 гаруй хүн оролцож, ардчиллын чухал институци болох

иргэний нийгмийн хөгжлийг дэмжих орчин цагийн зохицуулалттай болох зорилго дор талууд нэгдэж, хууль боловсруулах үйл явцад идэвхтэй хамтран ажиллахаар тохирсон болно.

ННФ хамтран зохион байгуулсан уг хэлэлцүүлэгт зориулж “Төрийн бус байгууллагын эрх зүйн орчны баримт бичгийн эмхэтгэл” гаргалаа.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ ЧИГЛЭЛД

ННФ нь иргэний нийгмийн байгууллага(ИНБ)-уудад олон нийтийн зүгээс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд хуулиар баталгаажсан иргэдийн оролцооны механизмуудыг ашиглан ардчилсан сайн засаглалыг бэхжүүлэх, хүний эрхийг хамгаалах чиглэлээр явуулж буй тэдний үйл ажиллагааг нь олон нийтэд таниулахад анхаарч ажиллалаа.

Иргэний нийгмийн орон зайд өрнөж буй өдөр тутмын үйл явдал, ИНБ болон идэвхтэн зүтгэлтнүүдийн сэдэл

зорилго, олсон амжилт, түүлж буй бэрхшээлийг олон нийтэд мэдээ, сэтгүүл зүйн бүтээл, баримтат нэвтрүүлэг хэлбэрээр хүргэж байна. Мэдээний урсгал, ТВ-ийн хөтөлбөрт тэр бүр тусаад байдаггүй иргэний нийгмийн мэдээ, мэдээллийн орон зайг бий болгох зорилготой энэ үйл ажиллагаа нь иргэний нийгмийнхнийг олон нийтэд танилцуулахын ялдамд нийтийн эрх ашиг, иргэдийн оролцоо, мөн иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг сурталчлах давхар ач холбогдолтой юм.



ТӨСӨВТ ХУРИМТЛУУЛСАН МӨНГӨ "АЛГА БОЛЖ", АМЬДРАЛ ДОРЙТООД БАЙГААД БИД Ч БУРУУТАЙ

О.Ариунбилэг 🕒 2022-12-23 15:59:00

"Үнэн хатамж" ТББ-ын Гүйцэтгэх захирал Ж.Сайнзаяа

“Үнэн хатамж” ТББ нь Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гээд төсөвтэй холбоотой бүхий л хуулийн хэрэгжилтэд мониторинг хийдэг тухай Гүйцэтгэх захирал Ж.Сайнзаяа ярьжээ. Олон хуулийн төсөлд санал өгсөн бөгөөд санал бүр нь тусаагүй ч төсөвт иргэний хяналт тавьдаг байгууллага гэж танигдаад байгаа ажээ. “...Хүн бүхэн ...төсөвт мөнгө хийдэг хэр нь тэр мөнгийг нь хэдхэн хүн дур зоргоороо цацаад дуусгаж байгаад анхаарал тавихгүй байж болохгүй. Бидний цуглуулсан мөнгө алга болоод, бидний амьдрал муудаад байгаа бол нэг талаар бид өөрсдөө буруутай болж таарна.”

Уг ТББ төсвөө хянахыг уриалахын зэрэгцээ хяналт тавихад иргэдийг сургах сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсон шалтгаанаа “Улсын төсөв гэхээр өөрсдөд нь хүртээлгүй, нэг л тийм хол юм гэж боддог хүмүүст энгийнээр буулгаад, хэлээд өгөхөөр хяналт тавих хэрэгтэй юм байна гэдэг” гэж тэр тайлбарлана. “Иргэн бүр бүх шатны төсөвтөө хяналт тавин, сайн сайханд хүрээсэй, төсөв нь тунгалаг, үр дүнтэй, иргэд нь сэтгэл хангалуун амьдрах үндэс болоосой” гэж цахим хуудсаа Сайн аудит гэж нэрлэжээ.

Тогтвортой хөгжлийн төлөөх сэтгүүлчид ТББ нь ННФ-ын дэмжлэгтэйгээр өөрийн mpress.mn сайт дээр “Индэр” булан, “Өөрчлөгчид” хуудас, мөн фейсбүүкт 14000 дагагчтай “Иргэний нийгмийн мэдээ” хуудас ажиллуулж, иргэний нийгмийн байгууллага, идэвхтнүүдийн үйл ажиллагааг мэдээлж байна. 2022 онд иргэний нийгмийн байгууллагуудын зохион байгуулж буй арга хэмжээний тухай 84 мэдээ, ТББ-ын үйл ажиллагааг танилцуулах зорилготой 10 сурвалжилга, мөн иргэний нийгмийн идэвхтэн,

манлайлагчдыг танилцуулах 10 нийтлэл гарчээ. Эдгээр нь иргэдийн оролцоо, төрд тавих хяналт, төрийн үйлчилгээний хүртээмж, хариуцлагатай үүл уурхай, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах зэрэг чухал асуудлыг хөндөж, өөр өөрийн чиглэл, зорилтыг хангахын тулд иргэний нийгмийн байгууллагуудын ашиглаж байгаа арга механизм, хүрсэн үр дүнг тусгахын зэрэгцээ иргэдийг идэвхжүүлэн сэдэлжүүлэх агуулгаар бүтээгджээ.



Н.ЭНХЖАРГАЛ

“АМЬД ХУУЛЬ ТӨВ” ТББ-Н ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ӨМГӨӨЛӨГЧ

Баянхонгор аймагт төсвийн хөрөнгөөр баригдсан барилгын эзэн солигдож, тэнд төрийн үйлчилгээ явуулахын тулд төсвөөс шинэ эзэнд нь түрээс төлж байгаа асуудлаар Амьд хууль төв ТББ-ын хуульчид шүүхэд ханджээ. Уйгагүй хөөцөлдсөөр, тухайн барилгыг нийтийн өмчөөс хасах хууль бус шийдвэрийг цуцлуулж, барилгыг төрийн өмчид буцаах шийдвэр гаргуулан, татвар төлөгчдийн мөнгийг үрэн таран хийж байсныг таслан зогсоожээ.

Иргэний нийгмийн байгууллага бүр өөрийн түүхтэй, өөрийн гэсэн ажлын арга барилтай. Засаглал, хүний эрхийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын түүх нь иргэдийн оролцоот ардчилсан засаглал, нийтийн эрх ашгийг үнэт зүйлээ болгож эвлэлдэн нэгдсэн сонирхолтой, сургамжтай, мөн бахархам түүхүүд байдаг. Тэдний төлөөлөл болох Баянхонгор аймгийн Амьд хууль төв ТББ, Ховд аймгийн Шинэ толь

ТББ, Дорнод аймгийн Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн ТББ-ын баялаг түүхийн багахан хэсгийг өгүүлсэн богино хэмжээний нэвтрүүлгүүдийг бэлдээд байна. Эдгээр ТББ-ын үйл ажиллагааны чиглэл, багийн бүтэц бүрдэл өөр ч гэлээ бүгд нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалах стратегийн өмгөөллийн арга механизмыг сонгож ажилласан ижил туршлагатай.



Д.ГАНЦОГТ

БУЙР НУУР, ХАЛХ ГОЛ, НӨМРӨГИЙН САВ ГАЗРЫН ХАМГААЛАХ САН ТББ-Н ТЭРГҮҮН

Дорнод аймагт газрын тос олборлох үйл ажиллагааны явцад төрөлх нутгийн нь онгон байгаль сүйдэж байгаа тухай хоорондоо ярилцдаг байсан нутгийн иргэд санаа шулуудан ТББ байгуулснаар Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн үүссэн түүхтэй. Нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалахаар стратегийн өмгөөллийн хэрэг үүсгэн ажилласны үр дүнд Монголд анх удаа байгаль бохирдуулсны нөхөн төлбөр төлүүлсэн нь 1 тэрбум гаруй төгрөг болжээ. Нутгийн иргэдийн туршлага, бодлогын нөлөөлөл нь Монгол Улсын уул уурхай, газрын тосны салбарт хууль, стандартуудыг бий болгоход хувь нэмэр болсон юм



Г.ТӨРМӨНХ

ХОВДЫН ТОЛЬ СОНИНЫ ЭРХЛЭГЧ

Ховд аймгийн Цэцэг сумын нутаг дах Мянган угалзатын нуруу хэмээх улсын тусгай хамгаалалттай газарт гар аргаар уул уурхайн үйл ажиллагаа явуулсны улмаас сүйдсэн байгаль орчныг нөхөн сэргээх аж ахуйн нэгжид тэндээ олборлолт хийж олсон мөнгөөр нөхөн сэргээлт хийх эрхийг аймгийн ИТХ олгожээ. Ховдын сэтгүүлчид олон тооны баримт нотолгоо цуглуулж, энэхүү авлигын шинжтэй ээдрээтэй хэргийг шүүхээр шийдүүлж, ИТХ-ын тогтоолыг хүчингүй болгуулж чаджээ.

Нийтийн эрх ашгийг сахин хамгаалахад төр, захиргааны байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор шүүхэд хандан, стратегийн өмгөөлөл хийсэн нь эдгээр байгууллагын үйл ажиллагааны нэгээхэн хэсэг бөгөөд энэ хэсгийг харуулсан баримтат нэвтрүүлгүүд орон нутгийн телевизээр гаргахад бэлэн болоод байна. Энэхүү цуврал нь иргэд

эвлэлдэн нэгдэж эрхээ хамгаалж байгаа түүхээр дамжуулан нийтийн эрх ашгийг тухай, иргэдийн эрх ашгийг хамгаалахад төр, захиргааны байгууллагын хүлээх үүрэг, захиргааны байгууллагын хариуцлагыг сайжруулахад шүүхийн оролцоо, цаашилбал, иргэд эвлэлдэн нэгдэхийн хүч зэрэг иргэний боловсролын чухал агуулгыг хүргэх юм.

АРДЧИЛАЛ, ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

Ардчилсан нийгэм нь залуу үеэ ардчилалд сургах үүрэг хариуцлагыг хүлээдэг. Ардчилсан тогтолцоотой улс орнуудын иргэний боловсролын хичээлээр дамжуулан ардчилсан тогтолцоо, хүний эрхийн мэдлэг, оролцооны түршлагыг залуу үедээ төлөвшүүлж ирсэн.

Манай улсад Иргэний боловсрол хичээлийн нэр, хөтөлбөр, агуулга өөрчлөгдсөөр одоо Иргэний ёс зүйн боловсрол гэсэн нэртэй, монгол уламжлалт арга ухаан, ардчиллын боловсролыг хослуулах зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Гэвч Иргэний ёс зүйн боловсрол хичээл нь сонгодог иргэний боловсролын агуулга, арга зүйг тусгаж чадаагүй гэсэн шүүмжлэл гарах боллоо. ННФ нь “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн эвсэлтэй хамтран Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн агуулга, зорилтыг хэлэлцэх техникийн уулзалтыг 2022 оны 12 сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Уг уулзалтад ардчиллын боловсрол, залуучуудын оролцооны чиглэлээр ажилладаг дотоодын болон олон улсын ТББ, багш бэлддэг их дээд сургуулийн судлаач нар оролцлоо. Уулзалтаар уг хичээлийн хөтөлбөрт ардчилсан засаглал, хүний эрх, сонгогчийн боловсролын агуулга нэн хязгаарлагдмал, багш төвтэй, мэдээлэл дамжуулах арга зүй давамгайл байгаа, мөн хүүхэд залуучуудад ёс зүйн мэдлэг олгох зорилго нь сайшаалтай боловч одоо байгаа агуулга нь ёс зүйн боловсрол болж чадахгүй байгааг оролцогчид онцлов.



Ардчилсан нийгэм бол цөөнхийн эрх ашгийг дээд зэргээр харгалзах үнэт зүйл дээр түшиглэн, олон талт байдлаа хүлээн зөвшөөрөн эв нэгдлээ хангаж амьдардаг. Үзэл бодлын цөөнх нь үгээ хэлэх эрх чөлөөгөөр хангагдаж, бэлгийн цөөнх нь хүний эрхийг эрх тэгш эдлэх, хөгжлийн цөөнх буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш хамрагдах бодлогын дэмжлэг авах эрхтэй бол хэлний цөөнхийн

эрх ашгийг хамгаалах бодлого бол хос хэл, хос хэлний боловсролын бодлого юм. ННФ нь академич Б.Жадамбаатай хамтран “Хос хэлний боловсролын бодлого, арга зүй” сэдэвт судалгаа гүйцэтгэлээ. Уг судалгаанд хос хэл бол боловсрол эзэмших бүх хүний эрх болон үндэстний цөөнхийн эх хэл, соёлоо хадгалан хөгжүүлэх эрхийн огтлолцол дээр орших онцлог асуудал болохыг онцлоод, хос хэлний боловсролын амжилт нь зөвхөн сургалтын хөтөлбөр, мэргэшсэн багш, сайн сурах бичгээр бий болохгүй, харин сургалтыг хос хэл дээрх мэдээллийн орчин, эцэг эхийн оролцоо, цөөнхийн хэлийг ашиглах боломж, сонирхлыг нэмэгдүүлэх зорилготой нийгмийн бодлогоор дэмжих шаардлагатай ажээ. Манайд хос хэлний боловсролын

хөтөлбөрийг БШУ-ны Сайд батлах ёстой ч энэ эрх мэдлээ Баян-Өлгийн аймгийн захиргаад шилжүүлсний улмаас аймгийн түвшинд шийдэх боломжгүй цагийн зохицуулалт, сурах бичгийн боловсруулалт болон хангамж, багшийн мэргэжлийн бэлтгэл зэрэг асуудал хуримтлагдаад байгааг судлаач анхааруулжээ. Арга зүйн хувьд хэлийг бие даасан хичээлээр заахын оронд зорилтот хоёр хэлийг бусад хичээлийг судлах хэл болгож ашиглаж замаар хэрэглээнд оруулах, нэг хичээл дээр хоёр хэлийг цувраа байдлаар ашиглах зэрэг хос хэлний сургалтын орчин үеийн арга зүйг тайлбарлан танилцуулж, Боловсролын хүрээлэн нь ийм арга зүйг Баян-Өлгий аймгийн сургуулиудад түршиж байгаа ажээ.



ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

“Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он

Төрийн эрх мэдэл хуваах онолын үүднээс шүүх эрх мэдэл нь төрийн нэрийн өмнөөс шударга ёс тогтоож, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй. Шүүх шударга ёсыг тогтоохдоо хууль дээдлэх зарчмын хүрээнд үйл ажиллагаа явуулж хүний зөрчигдсөн эрхийг сэргээх, иргэд, хуулийн этгээдийн хоорондын маргаан таслах замаар иргэдийн төрд итгэх итгэл, нийгмийн дэг журмыг хамгаалдаг.

ННФ нь 2008 оноос эхлэн Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд шүүхийн талаар бие даасан судалгаа шинжилгээ, мониторинг, ажиглалтаар дамжуулж талуудад мэдээлэл өгөх, санал солилцох орон зай бий болгоход анхаарч ирсэн юм.

2022 оны хувьд үйл ажиллагаагаа 2019 оны Үндсэн Хуулийн нэмэлт өөрчлөлт, 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүний хүрээнд гарсан тогтоол, журмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг судлах, хөндлөнгийн хараат бус судалгааны чадавх дэмжихэд чиглүүлээ.



Хөгжлийн банкны шүүх хурал. Эх сурвалж www.news.mn

УИХ-аас 2021 оны 1 дүгээр сарын 15-нд батлагдсан Шүүхийн тухай хууль 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн хэдий ч Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) болон Шүүхийн сахилгын хороо (ШСХ)-ны бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах ажил сорилт бэрхшээл дагуулсаар 2021 оны сүүлээр


эцэслэгдэж, 2022 онд бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж эхлэв. Энэ нэн чухал цаг үед шүүхийн шинэтгэлийг дэмжих чиглэлээр бид дараах ажлыг олон талын хамтын ажиллагааны хүрээндхийж гүйцэтгэлээ.

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ИНДЕКС

Шүүхийг хууль дээдлэх ёсны баталгаа болсон, иргэд шударга ёсыг эрэлхийлэн хандах, тэдний итгэлийг хүлээсэн, хараат бус байгууллага болгон шинэчлэх ажил 30 жил үргэлж байгаа ч олон нийтийн дундах шүүхийн тухай төсөөлөл сайжрахгүй, зарим талаар улам бүр дордсоор байна. Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бодлогын судалгаа, шинжилгээний үр дүн шүүхийн талаарх бодитой, хөндлөнгийн үнэлгээ, тулгамдаж буй асуудлын оновчтой нарийвчилсан оношилгоо нэн шаардлагатайг харуулсан болно. Иймд шүүхийн шинэтгэлийн үр нөлөөг тогтмол үнэлэх, ямар ахиц дэвшил, үхралт гарч байгааг тодорхойлох Шүүхийн индекс судалгааг санаачлав.

Шүүх эрх мэдлийн хүрээнд ажилладаг болон судалгаа шинжилгээ хийдэг эрдэмтдийн төлөөлөлтэй зөвлөлдөн, олон улсын туршлага, арга зүйг судалсны

үр дүнд үндэсний хэмжээний индекс тодорхойлох арга зүйг боловсруулж анхны тайланг 2021 оны байдлаар гаргаж олон нийтэд танилцууллаа. Шүүхийг олон нийтийн санал бодол, салбарын мэргэжилтнүүдийн санал бодол болон захиргааны өгөгдөл, мэдээлэл гэсэн гурван эх сурвалжид суурилсан 6 үндсэн хэмжигдэхүүнээр үнэлсэн юм. Шинээр томилогдон ажиллаж буй ШЕЗ нь индексийн дүнг дунд болон урт хугацааны стратеги бодлого боловсруулах нэгэн чухал эх сурвалж болгон ашиглаж байгаа нь энэхүү судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлж байна. Цаашид энэхүү индексийн судалгааг хоёр жил тутамд хийж, шүүхийн үйл ажиллагааг сайжруулах бодлогын зөвлөмж гаргаж ажиллах юм. Энэхүү судалгааг Оюуны Инновац ТББ, ММСГ судалгааны компани, Тунгаахуй өгөгдлийн урлантай хамтран ажиллаж гүйцэтгэсэн болно.



Монгол Улсын Шүүхийн Индекс танилцуулах арга хэмжээ, ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх бөгөөд энэ нь Монгол улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргах байдлаар хэрэгждэг. Ийнхүү иргэдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хохирлоо барагдуулах шийдвэр гаргахдаа хууль тогтоогчийн баталсан хуулийг нэг мөр хэрэглэж хууль дээдлэх зарчмыг баримтлан ажиллах учиртай.

Иргэдийн шүүхэд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж буй томоохон хүчин зүйл нь шүүх адил төстэй хэрэг, маргааныг өөр өөрөөр шийдвэрлэдэг, хуулийг өөрийн үзэмжээр тайлбарлан хэрэглэж байна гэх шүүмжлэл юм. Энэ нь шүүгчдийн шийдвэр гаргахдаа хэрэглэж буй хууль тогтоомжийн хийдэл, зохицуулалт тодорхойгүй байдлаас гадна хувь шүүгчийн мэргэжлийн ур чадвар, магадгүй хөндлөнгийн нөлөөлөлд автдагтай холбоотой байж болох юм. Шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх нь хуулийн хэрэглээг нэг мөр болгоход ач холбогдолтой гэж үзэж шүүхийн шийдвэрийн судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг 2018 оноос эхлэн хэрэгжүүлж 40 гаруй шинжилгээг нэгтгэсэн 5 эмхэтгэл, 9 цуврал нийтлээд байна.

2021 онд Шүүхийн шийдвэр судалгааны редакцын зөвлөл судалгааны сэдэв, судлаачдыг сонгон шалгаруулалтыг салбар эрх зүйгээр мэргэшсэн хуульч, судлаачдын оролцоотой хийж ирлээ. Үүний үр дүнд судалгааны эмхэтгэл эрүү, иргэн, захиргааны шүүхийн шийдвэрээр дагнах болсон бөгөөд 2022 оны хувьд 6 цувралд 16 тайланг нэгтгэн хэвлэн нийтэлж уншигчдын гарт хүргээд байна.

Шүүхийн шийдвэрийн судалгааны чанарыг дээшлүүлэх, агуулга арга зүйн хувьд боловсронгуй болгох үүднээс судалгааны тайланд шүүмж бичүүлж, түүнийгээ хэлэлцүүлдэг болсон нь судлаачдын хувьд үр өгөөжтэй ажил болж хэвшлээ. 2022 онд нийт 18 тайланд шүүмж хийлгэж, хэлэлцүүлэг зохион байгуулжээ.

2022 оны 3 сарын 1-нээс 12 сарын 31-нийг дуустал нээлттэй зарын дагуу нийт 24 төсөл хүлээн авснаас дараах 9 төслийг шалгаруулж, судалгааны тэтгэлэг олгосон байна.

Судлаач	Шүүхийн шийдвэрийн судалгааны сэдэв
А.Түвшинтөгс	Иргэний хуулийн 280 дугаар зүйлийн 281.1.1-д буй Бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн тохиолдолд бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцож буй шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа
Н.Давааням	Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ
П.Намуун	Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ
Д.Ганхүрэл, Б.Гүнбилэг нар	Амьтны учруулсан гэм хорыг арилгуулахтай холбогдох шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ
Ч.Баянжаргал ахлагчтай баг	Өв залгамжлал, гэрээслэлтэй холбоотой иргэний хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн харьцуулсан судалгаа
П.Намуун	Хүн худалдаалах болон Бэлгийн мөлжлөг гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ
Хууль дээдлэх ёс ТББ	"Хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч" үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик
Онч шийдэл ТББ	Төрийн захиргааны байгууллагын эс үйлдлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд хийсэн дүн шинжилгээ
Ө.Болортуяа ахлагчтай баг	Маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж, шинэ акт гаргахыг хариуцагчид даалгаж шийдвэрлэсэн захиргааны шүүхийн шийдвэрийн судалгаа

Хэвлэн нийтлэгдсэн шүүхийн шийдвэрийн судалгааг Оюуны Инноваци ТББ-тай хамтран LegalTalks подкастын түсгай цувралаар хүргэж эхэлсэн нь судалгааг эргэлтэд оруулсан чухал алхам боллоо.

Подкастыг www.forum.mn болон www.legaldata.mn хаягаар орж өөрийн хүссэн платформ, аппликэшнээр татан авч сонсох боломжтой.

МОНГОЛ УЛСАД СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛЖ БҮЙ ШҮҮХИЙН ПРАКТИК

1. Танилцуулга 00:00-06:15
 2. Сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх шаардлага, үндэслэл болон сэтгэл санаанд учирсан хохирлын айлголтын тухай 06:15-15:05
 3. Сэтгэл санааны хохирлыг гаргуулахад тулгамдаж буй асуудал, хууль эрх зүйн орчин, шүүхийн практик 15:05-21:07
 4. Сэтгэл санааны хохирлыг гаргуулахтай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааны санал, зөвлөмж, сорилт, үр дүн 21:07-30:25
 5. Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгаар өрсөн хохирлыг тогтоох зохицуулалт, үр дүн, шинэчлэлийн тухай 30:25

ХӨТӨЛӨГЧ:
П.Бадамрагчаа: Нээлттэй Нийгэм Форумын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

ЗОЧИН:
А.Түвшинтөгс: Өмгөөллийн Номун түншлэл компанийн өмгөөлөгч

"Шүүхийн шийдвэрийн судалгаа" цуврал подкаст

S2 EP1

МОНГОЛ УЛС

ШҮҮХИЙН ИНДЕКС

2021

judindex.forum.mn

Шүүхийн индексийн тайлантай judindex.forum.mn цахим хуудаст хандан дэлгэрэнгүй танилцах боломжтой.

ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨН, БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

“Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.”

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.6-д хэсэг (Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн)

Шүүхийн сахилгын хороо нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй 5 гишүүн нь нээлттэй үйл явцын дагуу нэр дэвшиж, томилогддог Монгол Улсын Үндсэн хуулийн байгууллага юм. Шүүхийн тухай шинэ хуульд шүүгчийн сахилгын маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчилсан процессыг дэлгэрэнгүй зааж өгсөн нь тус хуулийн нэгэн чухал зохицуулалт билээ. Шинэ тутам байгуулагдсан энэхүү байгууллагад шүүгчтэй холбоотой ирсэн гомдол мэдээллийг тухай бүрд нь бүртгэх, гомдол шалгах гишүүнийг

санамсаргүй, тохиолдлын журмаар томилох, маргаан шийдвэрлэх хугацаа тооцох, холбогдох шийдвэрийг цаг тухайд нь бүртгэх, мэдээлэх, гомдол шийдвэрлэлтийн мэдээлэл, тайлан боловсруулах зэрэг ажиллагааг хэрэгжүүлэх бие даасан систем хөгжүүлэх, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүллээ. Энэхүү систем нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны хараат бус, үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭРХ СУДАЛГААНЫ ДЭМЖЛЭГ

ШЕЗ нь шүүхийн ил тод нээлттэй үйл ажиллагааг бэхжүүлэх үүднээс дотоод журам, дүрмийн шинэчлэлийг эрчимтэй хийж байна. ННФ-ын дэмжлэгтэй хийгдсэн шүүхийн шийдвэрийн цахим сангийн үйл ажиллагаанд хийсэн мониторингийн үр дүнд тулгуурлан Шүүхийн шийдвэрийг цахимаар нийтлэх журам шинэчлэн батлагдаад байна.

2021 оны Шүүхийн индексийн оноог доош татсан хэмжигдэхүүн нь шүүхийн дэд бүтэц, нөөцийн асуудал байв. Иймээс бид шүүхийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах, шүүхийн байрны стандарт боловсруулахад шаардлагатай суурь судалгааг Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэнгийн судалгааны багт захиалан, судалгааны тайланг ШЕЗ-д хүлээлгэн өглөө.

Судалгааны хүрээнд шүүхийн байрны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, бусад улс орны шүүхийн туршлагыг судалсны дүнд шүүхийн зүгээс иргэдэд хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын ажиллах орчныг сайжруулахад шаардлагатай санал зөвлөмжийг боловсруулан танилцууллаа. Одоогийн байдлаар нийт 7 шүүх бусдын өмчлөлийн байранд түрээсийн төлбөр төлж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 8 шүүх прокурорын байгууллагатай нэг байранд байрлаж байна. Энэ нь шүүхийг бие даасан, хараат бус байдлын хувьд эмзэг болгож байгаагийн зэрэгцээ шүүхийн нийтэд үйлчлэх зай талбай, захиргааны ажилтнууд ажиллах өрөө тасалгаа нэн дутмаг байгаа нь шүүхийн үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж байна.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ

Монгол Улсын иргэн... 13| халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дугаар хэсэг

ННФ-ын Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр нь Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бие даасан судалгаа, мониторингийн үр дүнгээр хангахын зэрэгцээ, шинэ эрх зүйн орчинд ажиллах эрх зүйн соёлыг төлөвшүүлэх, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг боловсруулах шатанд иргэний нийгмийн санал бодлыг нэгтгэн хүргэхийг зорьж ирлээ. Энэ онд цар тахлын улмаас тулгарч буй сорилтыг даван түүлах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сүүлийн жилүүдэд хийгдэж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг үнэлэхэд гол анхаарлаа хандууллаа.



#NoWar жагсаалын үеэр. Эх сурвалж: жагсаалд оролцогчийн твитер хуудас

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ГҮНЗГИЙРҮҮЛЭХ БОДЛОГЫН СУДАЛГАА

ННФ нь эрүүгийн эрх зүйн шинэтгэлийг дэмжих зорилгоор хараат бус бодлогын судалгааг дэмжиж ирлээ. 2022 онд дараах судалгааг дэмжин, олон нийтийн хүртээл болгож ажиллалаа. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн давхардал,
2. Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, хэсгийн хэрэгжилт,
3. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт,
4. Кибер гэмт хэргийн зохицуулалтын харьцуулсан судалгаа,
5. Мөрдөх албаны талаарх харьцуулсан судалгаа,
6. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахад тулгамдаж буй асуудал,
7. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал,
8. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа: Тулгамдаж буй асуудал,
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлгийн хэрэгжилт,
10. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ,
11. Сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт,
12. ЭХХША дахь өмгөөлөгчийн оролцоог үр нөлөөтэй болгох асуудал,
13. Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага, түүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэж буй практик, тулгамдаж буй асуудал,
14. Тайван жагсаал, цуглаан хийх эрх: Тулгамдсан асуудал, шийдэл, гарц,
15. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь зөвшөөрөл, тулгамдсан асуудал,
16. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, түүний хэрэгжилтийн байдал,
17. Гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцооны харьцуулсан судалгаа зэрэг хамаарна.



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ХҮРЭЭНИЙ БОДЛОГЫН НӨЛӨӨЛӨЛ

Эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа нь хүний эрхэд нийцсэн, шударга процессод тулгуурласан байх учиртай бөгөөд энэ зорилгоор бодлогын хэлэлцүүлэг, сургалт, техник туслалцаа, стратегийн өмгөөлөл, мэдээлэл, гарын авлага боловсруулах зэрэг олон талын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа.

2022 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэд хэдэн хуулийн төсөл УИХ дээр хэлэлцэгдэж эхэлсэн бөгөөд зарим талаар хүний эрхийн хувьд үхралт гарч болохуйц нөхцөл үүсээд байгаа тул тулгамдаж буй дараах асуудлыг хөндсөн цуврал хэлэлцүүлгийг ХЭҮК, ХЗДХЯ, МХХ, МӨХ-той хамтран зохион байгуулж, цахимаар шууд дамжуулсан билээ. Үүнд:

- ЭХХШТХ-ийн 31-р бүлгийн хүрээнд тулгамдаж буй асуудал,

- Мөрдөн шалгах нууц ажиллагаа
- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг
- Эрүүгийн процесс ба Хүний эрх.

Хэлэлцүүлгийн үр дүнг Чухал сэдэв цувралд нийтэллээ.



"Эрүүгийн процесс ба Хүний эрх" хэлэлцүүлэг, ХЭҮК-ийн гишүүн С.Дондов, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан

Сэжигтэн, яллагдагч нь хууль зүйн туслалцааг аль болох эрт шатанд авснаар эрх нь зөрчигдөхгүй байх нөхцөл бүрддэг. 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар энэ баталгааг бүрдүүлэхэд зарим ахиц гарсан ч практикт үр дүн өөр байгаа болох нь бодлогын судалгаа, хүний эрхийн мэргэжилтний дүгнэлт зэргээр батлагдах болсон. Тухайлбал, 2020, 2021 оны нийт баривчилгаа (99%, 98%) шүүхийн зөвшөөрөлгүй явагдсан тухай НҮБ-ын Ажлын хэсгийн дүгнэлт үүнийг тод гэрчилнэ. Тиймээс эрүүгийн процесст хууль зүйн туслалцаа авахад тулгамдаж

буй асуудал, гарц шийдлийг олон талын оролцоотой хэлэлцэж, санал, зөвлөмжийг холбогдох талын анхааралд хүргэх, энэ асуудалд олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах зорилгоор “Эрүүгийн процесст хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах нь” сэдэвт хэлэлцүүлгийг ХЗДХЯ, Хууль зүйн туслалцааны төв, МХХ, МӨХ, Оюуны инноваци ТББ-тай хамтран зохион байгууллаа. Хурлын үеэр тус хөтөлбөрөөс энэ чиглэлээр хийгдсэн болон хийгдэж буй 3 судалгаа хэлэлцүүлэгдлээ.



“Эрүүгийн процесст хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах нь” сэдэвт хэлэлцүүлгийн оролцогчид, 2022 оны 12 сар

Түүнчлэн Монголыг хуульчдын холбоо (МХХ), Монголын өмгөөлөгчдийн холбоо (МӨХ)-той хамтран хоёр кредитийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 2022 оны 11-р сард магадлан итгэмжлүүлээ. Тус сургалтын хөтөлбөр нь шинэ эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэх үр чадварыг өмгөөлөгчдөд олгох замаар эрүүгийн процесст чанартай хууль зүйн туслалцаа авах иргэний эрхийг хангах зорилготой юм. Кредит олгох анхны сургалтад Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран Монгол Улсад үйлдэгдэж буй 20 гаруй мянган гэмт хэргийн холбогдогчдын дийлэнх болох төлбөрийн чадваргүй яллагдагч, шүүгдэгч нарт хууль

зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий улсын өмгөөлөгчдийг хамруулсан нь өндөр ач холбогдолтой байлаа.

Хүний эрхэд нийцсэн, шударга процесс бүхий хэрэг бүртгэх, мөрдөн шалгах албыг бэхжүүлэхэд эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэл хийгдэж байгаа ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд оролцогчдын эрхийг хууль бусаар хязгаарласан, зөрчсөн дүрэм, журам цөөнгүй үйлчилсээр байгаа талаар шүүмжлэл өрнөсөөр байна. Эдгээр хүний эрхэд халтай журам, практикийг халах, хуулиар тогтоосон зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд хөшүүрэг болгох үүднээс

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Оюуны инноваци төрийн бус байгууллагуудад стратегийн өмгөөллийн тэтгэлэг олголоо. Стратегийн өмгөөллийн зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өмгөөлөгч холбогдох газруудад саадгүй нэвтрэх бололцоо бүрдүүлэх явдал юм.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг зэрэг шинэ зохицуулалт бий болгосон нь хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр гарсан томоохон ахиц билээ. Тус шинэ зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хөндлөнгийн ажиглалт, мониторинг чухал ач холбогдолтой тул энэ асуудлаар сонирхогч талуудад хандсан гарын авлага боловсрууллаа. Гэвч энэ үйл явцад хөндлөнгийн ажиглалт, мониторинг хийх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, практик ч тогтоогүй байгаа тул энэ чиглэлээр эхэлж ажиллах шаардлага тулгарч байна.

ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ

ННФ-аас хохирлын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх чиглэлээр цуврал судалгаа хийж олон нийтэд танилцуулж байгаа бөгөөд “Гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцооны харьцуулсан судалгаа”-г Монголын Криминологичдын Холбоо хийж гүйцэтгэлээ.

2021 онд “Хохиролгүй барагдууль” цахим аяны хүрээнд сайн жишиг тогтоох зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх”, “Цагаан эрэг”-ийн хохирлыг арилгах”, “Ковид-19 цар тахлын үед захиргааны хууль бус шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг барагдуулах”, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах” зэрэг асуудлаар

Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдан мөрдөгдөөд багагүй хугацаа өнгөрч байгаа ч энэ асуудлаар нийгэмд багагүй маргаан мэтгэлцээн өрнөсөөр байгаа билээ. Эдгээр хуулиудад суурь судалгаа хийлгэн, судалгааны үр дүнг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлэх, хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт боловсруулах ажлын хэсгийн гишүүд АНУ-ын түршлага судлахад санхүүжилт олгох зэргээр дэмжлэг үзүүлээ.

ННФ нь анхны Хуульчдын Форум зохион байгуулагдахаас эхлэн эрх зүйн шинэчлэлийн тодорхой сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр дэмжин оролцож байв. Энэ удаагийн форумын “Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлийг эрүүгийн хууль тогтоомжоор хамгаалах нь” салбар хуралдаанд тус хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан хэлэлцүүлэгчээр орж, эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийсэн судалгаа, мониторингийн дүнг хуваалцлаа.

стратегийн өмгөөллийн төсөл хэрэгжүүлсэн билээ.

Төсөл хэрэгжүүлсэн зарим багийн гишүүд хүчин төгөлдөр бус захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагавар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас үүссэн сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх асуудлаар ХЗДХЯ-наас хуулийн төсөл боловсруулах албан ёсны ажлын хэсэгт орж ажилласан бол Ховд аймгийн “Цагаан эрэг”-ийн хохирлыг барагдуулах төслийн багийнхан орон нутгийн түвшинд хэлэлцүүлэг өрнүүлж, төрийн байгууллагаас мэдээлэл хүсэж, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ажиглалт хийх зэргээр нөлөөллийн үйл ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлж байна.



**НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА,
ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ**

ТӨСВИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монгол Улс байгалийн асар их баялагтай боловч хүн амын орлогын ялгаатай байдал гүнзгийрч, нийт хүн амын 30 хувь нь үндэсний ядуурлын шугамаас доогуур амьдарч байна.

Нийтийн баялгийг урт хугацааны хөгжлийн зорилгод нийцүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлэх, улмаар хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд Улсын төсвийн удирдлагыг эрс сайжруулах шаардлага цаг үеийн нэн тулгамдсан асуудал болж байна.

ННФ Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөрийнхөө хүрээнд улсын төсөв, санхүүгийн удирдлага, цаг үеийн асуудлуудаар тогтмол судалгаа, шинжилгээ хийх, үр дүнг нийтэд хүргэх, төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлдэг иргэний нийгмийн байгууллагуудад тэтгэлгийн дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ЧИГЛҮҮЛЭХ НЬ

“Төсвийн Зөвлөл” нь нийтийн сан хөмрөгийн оновчтой зарцуулалтыг дэмжих зорилгын дор хараат бус шинжээчдээс бүрдэн байгуулагдсан бөгөөд үг үйл ажиллагаанд иргэд мэдээлэлтэй оролцох, хяналт тавих боломж нөхцөлийг нэмэгдүүлэхийг чухалчлан ажиллаж байна. Үг Зөвлөлийн үйл ажиллагаагаар иргэний нийгмийн зүгээс хийх төсвийн



Төсвийн зөвлөлийн гишүүд УИХ-ын Төсвийн байнгын хорооноос зохион байгуулсан “Төсвийн бодлогын шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцож буй нь, 2022 оны 9 дүгээр сар

дүн шинжилгээ тогтворжиж, төсвийн чиглэлээрх цаг үеийн асуудлуудад анализ бүхий шүүрхай хариу үзүүлдэг болох, төсвийг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулах, оновчтой зарцуулалт бий болгоход хувь нэмэр оруулна хэмээн үзэж буй.

Төрийн зүгээс төсөв, санхүүд тавих хяналтаа сайжруулах, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлого шийдвэрт иргэдийн дуу хоолойг тусгах ажилд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ННФ-аас санаачлан 2021 оны 3 дугаар сард “Төсвийн Зөвлөл”-ийг байгуулсан билээ. Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Төсвийн Зөвлөл нь 2022 онд улсын төсөв, санхүүгийн асуудлуудаар хэлэлцэн, бодлогын шинжилгээ хийж, үр дүнг бодлого боловсруулагчид,

олон нийтэд хүргэж ажиллав. Тухайлбал, Зөвлөлөөс Монгол Улс дахь инфляцын нөхцөл байдал болон дефолтын эрсдэл (<https://forum.mn/product/241438>), улсын төсвийн төлөвлөлтийн анхаарах асуудлаар (<https://forum.mn/product/237856>) хэлэлцүүлгүүд хийж, үр дүнг “Төсвийн шинжилгээ” цувралд нийтлэн нийтэд хүргэлээ. Түүнчлэн Төсвийн зөвлөл нь 2023 оны улсын төсвийн төлөвлөлт, 2021 оны улсын төсвийн гүйцэтгэлийн аудитын дүнг хэлэлцэн санал, зөвлөмж гаргалаа. Мөн Уул уурхай хүнд үйлдвэрлэлийн яамнаас боловсруулсан Үндэсний баялгийн сангийн тухай болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төслүүдийг ННФ-ын “Байгалийн баялгийн засаглал” хөтөлбөртэй хамтран хэлэлцэж, санал, шүүмж (<https://forum.mn/product/211536>) боловсруулан нийтэд хүргэв.



Төсвийн зөвлөлийн гишүүн Н.Энхбаяр, Зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Оюунбадам нар 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын анхаарах асуудлаар Eagle ТВ-д ярилцлага өгч буй нь, 2022 оны 11 дүгээр сар

Цаашилбал, Төсвийн зөвлөлийн гишүүд УИХ-ын Төсвийн байнгын хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулсан “Төсвийн бодлогын шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэгт оролцон санал, зөвлөмж гаргалаа. УИХ-ын Төсвийн байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сард хийсэн “Төсөв 2023” олон нийтийн хэлэлцүүлгийн “Төсвийн ил тод байдал” сэдэвт салбар хэлэлцүүлэгт мөн Төсвийн зөвлөлийн гишүүд оролцон саналаа илэрхийлэв.

Тэрчлэн төсөв, санхүүгийн удирдлагыг хөгжлийн бодлогод чиглүүлэх хүрээнд хараат бус судлаачдын зүгээс судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт,


зөвлөмж гаргалаа. Судлаачдын зүгээс “Бүс Ба Зам” санаачилгын төслүүд дэх Монгол Улсын оролцоо, нөлөөлөл, Засгийн газраас боловсруулсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөтөлбөрт тусгасан бодлогын оновчтой байдал, төсөв болон мөнгөний бодлогын зарчмуудтай уялдах байдал, Улсын хөгжлийн төлөвлөгөө ба төсвийн уялдаа, төсвийн гүйцэтгэл ба тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт зэрэг чиглэлээр судаллаа. Үүнээс гадна Монгол Улсын өрийн тогтвортой байдал, төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гэрээнүүдэд дүн шинжилгээ хийж байна.



Тогтвортой хөгжлийн зорилтууддаа хүрэхийн тулд улс орнууд санхүүгийн нөөцөө хүртээмжтэй өсөлтийг дэмжих, нийгэм дэх эмзэг бүлэгт хүргэж буй үйлчилгээг сайжруулахад илүүтэй чиглүүлэх талаар олон улсын судлаачид зөвлөдөг. Олон улсын төсвийн түншлэл байгууллагатай өрнүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд бид “Төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэл ба тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт”-ийн судалгааг хийлээ. Уг судалгаа нь төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн зөрүү нь иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх, ядуурлыг бууруулах зорилгууддаа улс орнууд хүрэхэд нөлөөлж буй эсэхийг тодорхойлох зорилготой ба энэхүү судалгааны хүрээнд манай улсын 7 салбарын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл болон Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт ямар байгааг судалсан юм. Тус байгууллагаас төсөлд оролцсон орнуудын судалгааны дүнг нэгтгэн тайлан⁵ гаргаж, нийтэд хүргэсэн юм.

Бидний зүгээс бодлогын асуудал дэвшүүлсэн нийтлэлдээ болон уулзалт, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд дахин давтагдашгүй код олгон хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийг иргэд хянах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг хөндөн ажиллаж ирсэн билээ. Үүний дүнд Төсвийн тухай хуульд 2022 оны 11-р сард орсон өөрчлөлтөөр төслийн код нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдаж үүсгэснээс хойш тухайн төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байхаар туссан нааштай өөрчлөлт гараад байна.

Төсвийн ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах асуудлуудаар бодлогын түвшинд нөлөөллийн ажил хийхээс гадна бидний зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл хүргэх, зарим төрийн байгууллагын хурал, зөвлөгөөнд илтгэл тавих хэлбэрээр хамтран ажиллаж ирлээ. Тухайлбал, Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл хэлэлцэж буйтай холбогдуулан 2022 оны 10-11 дүгээр сард зарим анхаарах асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэл хүргэлээ.



Д.Төмөрпүрэв ахлагчтай баг БНХАУ-ын санаачилсан “Бүс ба Зам” төслийн хүрээнд манай улсад санхүүжүүлэх төслүүд болон зээл, түслэмжийн мэдээллийн нээлттэй байдал сул байна.
(<https://forum.mn/product/233473>)




А.Батпүрэв “Шинэ сэргэлтийн бодлого” хөтөлбөрийн агуулгын хүрээнд баримталж буй бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ нь тулгарч буй асуудлыг хэрхэн оношилж шийдвэрлэх оновчтой хувилбар дэвшүүлсэн эсэхэд төвлөрч олон улсын практикт харьцуулан санал, дүгнэлт өгөх үүднээс энэхүү хөндлөнгийн тойм судалгааг хийж гүйцэтгэв.
(<https://forum.mn/product/211533>)



Э.Цогбаяр Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн уялдааг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулагчдын зүгээс анхаарах нь зүйтэй байна. Тухайлбал, Эдийн засаг, хөгжлийн яам болон Сангийн яам илүү нягт уялдаатай хамтран ажиллах шаардлагатай байна.
(<https://forum.mn/post/128649>)

ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ



⁵ <https://internationalbudget.org/publications/connecting-budget-credibility-to-the-sustainable-development-goals/>

Улсын төсвийн ил тод байдал, төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо, төрийн хяналтын байгууллагуудын зүгээс төсөвт тавих хяналтын түвшнийг өнөөгийн түвшнээс дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах чиглэлээр бид мөн ажиллалаа. Үүнд, Олон улсын төсвийн түншлэл (www.internationalbudget.org) байгууллагаас 2 жил тутамд эрхлэн гаргадаг “Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа”-ны Монгол Улсын үнэлгээг хийж гүйцэтгэн, дүнг нийтэд танилцууллаа. 2021 оны судалгааны дүнгээс харахад Монгол Улсын Засгийн газрын төсвийн ил тод байдал дээшилсэн боловч төсвийн үйл явцад иргэд оролцох боломжийг олгож буй байдал хангалтгүй хэвээр байна. Тухайлбал, нийт авбал зохих 100 онооноос төсвийн нээлттэй байдлаар 60 авсан бол олон нийтийн оролцоогоор дөнгөж 13 авсан байна. Төсвийн хяналтын тогтолцооны үзүүлэлтээр 76 оноогоор үнэлэгджээ.

Судалгааны дүгнэлт, зөвлөмжийг ННФ-ын Хөтөлбөрийн менежерийн зүгээс УИХ-ын Төсвийн байнгын хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулсан “Төсвийн бодлогын шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр болон Үндэсний аудитын газраас 8 дугаар сард зохион байгуулсан “Төрийн хяналт – аудит 100 жил” онол, практикийн бага хуралд танилцуулав. Үүний дүнд Монгол Улсад анх удаа УИХ-ын Төсвийн байнгын хорооноос 2023 оны улсын төсвийн төлөвлөлтийн асуудлаар нийтийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. УИХ-ын Төсвийн байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сард зохион байгуулсан “Төсөв 2023” олон нийтийн хэлэлцүүлгийн “Төсвийн ил тод байдал” сэдэвт салбар хэлэлцүүлэгт ННФ-ын Хөтөлбөрийн менежер улсын төсвийн ил тод байдал, удирдлагын чиглэлээр анхаарах асуудлаар мөн танилцуулга хийсэн юм. Түүнчлэн “Төсвийн нээлттэй байдал 2021” судалгааны дүнгийн талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөх уулзалт зохион байгуулснаас гадна хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэл хүргэсэн юм.

Төсвийн нээлттэй байдлын судалгаа 2021

Монгол Улс

Судалгааны тухай

Засгийн газрын төсвийн талаарх шийдвэрүүд тухайлбал, ямар татвар ногдуулах, төрийн ямар үйлчилгээ үзүүлэх, өрийн хэмжээ хэд байх зэрэг нь нийгэм дэх бүх хүнд чухал үр дагавартай. Засгийн газар эдгээр шийдвэр гаргалтад шаардагдах мэдээллийг олон нийтэд түгээж, тэдгээрийн зүгээс оролцох боломжийг хангах бодит сувгуудыг бүрдүүлснээр нийтийн мөнгийг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн зарцуулж буйг баталгаажуулах илүү боломжтой болно.

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгууруудыг ашигладаг хараат бус, харьцуулсан болон нотлох баримтад суурилсан дэлхийн цорын ганц судалгааны арга хэрэгсэл юм. Тухайлбал, засгийн газрын төсвийн мэдээллийг олон нийт авах боломж, улсын төсвийн үйл явцад олон нийтийн зүгээс оролцох албан ёсны боломжит сувгууд, мөн хууль тогтоох болон аудитын байгууллага зэрэг төсвийн хяналтын институциуд төсвийн үйл явцыг хянахад гүйцэтгэж буй үүргийг үнэлэх шалгууруудад тулгуурлан хийгддэг.

Уг судалгаа нь тухайн улсын иргэний нийгэмд өөрийн улсын засгийн газартай нийтийн хөрөнгийн ашиглалт болон энэ талаар өгч буй мэдээлэлд үнэлгээ өгч, зөвлөлдөхөд туслах зорилготой юм. Төсвийн нээлттэй байдлын судалгааны энэхүү 8 дахь хэвлэл нь дэлхийн 120 орныг хамарсан болно.

www.internationalbudget.org/open-budget-survey цахим хуудаснаас судалгааны бүрэн аргачлал, 2021 оны дэлхийн тайлан, судалгаанд хамрагдсан улс орнуудын дүн, өгөгдлийн сан зэрэг илүү дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

Төсвийн нээлттэй байдлын судалгаа 2021

International Budget Partnership

Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа 2021: Монгол Улсын үнэлгээ

Засгийн газрын төсвийн талаарх шийдвэрүүд тухайлбал, ямар татвар ногдуулах, төрийн ямар үйлчилгээ үзүүлэх, өрийн хэмжээ хэд байх зэрэг нь иргэдэд чухал үр дагавартай. Засгийн газар эдгээр шийдвэр гаргалтад шаардагдах мэдээллийг олон нийтэд түгээж, тэдгээрийн зүгээс оролцох боломжийг хангах нь нийтийн төсвийн зарцуулалтыг оновчтой болгоход чухал юм.

(<https://forum.mn/product/241448>)

Төсвийн нээлттэй байдлын судалгааны дүгнэлт, зөвлөмжийг төр засгийн байгууллагуудад хүргэж ажилласнаар Сангийн яамны зүгээс иргэдийн төсвийг тогтмол нийтэлдэг болоод байна. Манай улсын хувьд төсвийн хагас жилийн тайланг нийтэлсэн ахиц дэвшил 2021 онд гарсан юм. Энэхүү тайланд олон улсын сайн туршлагын дагуу төсвийн оны эцсээрх хүлээгдэж буй гүйцэтгэлийн талаарх шинэчилсэн таамаглалыг багтаадаг болох нь зүйтэй юм.

Монгол Улс гадаад өрийн хэмжээг зохих түвшинд байлгахад анхаарах шаардлага нэн тулгамдаж байна. Манай улс уул уурхайгаас ихээхэн хамааралтай, дотоодын үйлдвэрлэл сүл хөгжсөн, харьцангуй жижиг эдийн засагтайн улмаас хэрэглээнийхээ дийлэнх хэсгийг импортоор хангадаг билээ. Импортоос ихээхэн хамааралтай эдийн засгийн хувьд гадаад өрийг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан хувь хэмжээг томоохон эдийн засагтай орнуудын түвшнээс доогуур байлгахыг олон улсын байгууллагууд, судлаачдын зүгээс зөвлөдөг. Улсын нийт гадаад өр 2022 оны эхний хагас жилийн байдлаар 33.3 тэрбум

ам. доллар буюу ДНБ-ий 238 хувьтай тэнцэж байна. Үүнээс 8 тэрбум гаруй ам. доллар нь Засгийн газрын өр бөгөөд Засгийн газрын зүгээс төлөх гадаад өрийн эргэн төлөлтөд хүндрэл учирч, улмаар өрийг дахин санхүүжүүлэх байдал сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Засгийн газар гадаад зээлийг олон тооны төсөл, хөтөлбөрт зарцуулж байна. Эдгээр зээлийн эргэн төлөлт улсын төсвөөс хийгдэх тул төслүүдийн үр ашиг, зарцуулалтын мэдээллийн нээлттэй байдлыг хангаж олон нийт хяналт тавих боломж олгох нь чухал болж байна. Иймд Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдлын судалгааг хийж гүйцэтгэлээ.

Түүнчлэн Шилэн дансны хууль, журмыг боловсронгуй болгох, Шилэн дансны цахим хуудсыг нээлттэй стандартад нийцүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг түргэсгэхэд хувь нэмэр оруулах үүднээс Сангийн яамнаас боловсруулсан Шилэн дансны тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд санал, шүүмж боловсруулах ажлыг судлаачид хийж байна.

С.Баттулгаар ахлуулсан ба “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, түслэмжийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.

(<https://forum.mn/post/128389>)



ТӨСВИЙН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийтийн хөрөнгийн зарцуулалтыг үр ашигтай болгох, төсөвт иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах үүднээс бид иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төрийн аудитын байгууллагатай хамтын ажиллагаа өрнүүлэх зэргээр ажиллалаа. Тухайлбал, “Монголын залуучуудын эвсэл” ТББ-аас Нийслэл, дүүргүүдийн 2023 оны төсвийн зарлагын төлөвлөлтийг ажиглах, зарцуулалтад мониторинг хийх, “Бодлогод залуусын хяналт” ТББ-аас иргэд төсвийн хэрэгжилтийг хянах аргачлалын гарын авлага боловсруулах, чадавхжуулах, “Хэрэглэгч сан” ТББ-аас Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын мониторинг хийх төслүүдэд тус тус тэтгэлгийн дэмжлэг үзүүлэв. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвөөс жил бүр хийдэг аймгуудын өрсөлдөх чадварын судалгаанд орон нутгийн төсвийн ил тод байдлын үзүүлэлтийг оруулахад мөн дэмжлэг үзүүлээ.

“Монголын залуучуудын эвсэл” ТББ-аас Нийслэл, дүүргүүдийн 2023 оны төсвийн зарлагын төлөвлөлтийг ажиглах, зарцуулалтад мониторинг хийх төслийн хүрээнд Нийслэл, 9 дүүргийн 2023 оны төсвийн зарлагын төлөвлөлт, хэрэгжилтийг олон нийтийн анхааралд оруулахаар олон нийтийн сүлжээний нөлөөллийн ажил хийж байна. Энэ хүрээнд зарлагын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, постер мэдээллийг тогтмол түгээж ажиллав. Мөн төслийн хүрээнд дүүргүүдийн 2023 оны төсвийг цахимд нийтлүүлэх шаардлага хүргүүлж ажилласнаар, дүүргүүд төсвөө цахимд нийтэлсэн нь иргэд дүүргийнхээ төсөвтэй танилцах боломжтой болсон байна. Тус ТББ-аас Нийслэл, дүүргүүдийн төсвийн зарцуулалтад

мониторинг хийх, төсөвт нийтийн анхаарлыг хандуулах ажлаа 2023 онд мөн үргэлжлүүлэн хийх юм.

Түүнчлэн “Бодлогод залуусын хяналт” ТББ-аас хэрэгжүүлж буй “Орон нутгийн төсвөө хянацгаая, залуус аа!” хөтөлбөрт 20 оролцогчийг хамруулан сургалт, цуврал зочин лекц зохион байгуулав. Хөтөлбөрт оролцож буй залуус төсвийг мөшгөх буюу тодорхой орон нутгийн жишээн дээр мониторинг хийх ажлууд хийж байна.

Нийтийн төсөв, санхүүд хууль тогтоох байгууллагын зүгээс тавих хяналтын эрхзүйн орчинд нааштай өөрчлөлт гарлаа. Тухайлбал, УИХ-ын хяналт шалгалтын тухай анхдагч хууль 2021 оны 12 дугаар сард батлагдсан билээ. Уг хуулийн хүрээнд нийтийн төсөв, хөрөнгийн удирдлагад тавих УИХ-ын хяналт сайжирснаар төсвийн зарцуулалтын үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой юм. Иймд шинээр хэрэгжиж буй энэхүү хуулийн хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулах үүднээс ИНБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлээ. Тухайлбал, төсөв, санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлын чиглэлээр шинээр хэрэгжих хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахад нөлөөлөл үзүүлэх зорилгоор “Хөх-Ах” ТББ-аас Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах үүрэг бүхий УИХ-ын Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны процесст ажиглалт хийх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах төсөл хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд Хөгжлийн банкны өнөөгийн үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийн талаарх мэдээллийг түлхүү бэлтгэж, олон нийтэд мэдээлж ажилласан юм.



“Орон нутгийн төсвөө хянацгаая, залуус аа!” хөтөлбөрийн сургалтын явцаас, 2022 оны 11 дүгээр сар

Түүнчлэн, төсвийн зарцуулалтад иргэний нийгмийн хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлэх үүднээс Монгол Улсын төсвийн төлөвлөлт, УИХ-аар төсвийн төслийг хэлэлцэж, баталж буй байдалд иргэдийн зүгээс хяналт тавихад ашиглах хялбар гарын авлагыг судлаач А.Батпүрэв боловсруулав. Гарын авлагад улсын төсвийн төлөвлөлтийн шатанд иргэд хэзээ, хаанаас төсвийн мэдээлэл авч болох, ямар шалгуураар төсвийг шинжлэх, төсвийн төлөвлөлтөд хэрхэн оролцох, хяналт тавих аргачлалыг багтааснаас гадна Монгол Улсын нэгдсэн төсөв юунаас бүрддэг, яагаад

төсөвт олон нийтийн хяналт чухал талаарх ойлголтыг тусгасан болно.

Цаашилбал, төсвийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор төрийн хяналтын байгууллагуудтай түншлэн ажиллах хүрээнд ННФ нь Үндэсний аудитын газраас нийтэд хүргэх аудитын мэдээллийн үрсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа. Энэ хүрээнд олон нийтэд төрийн аудитын байгууллага, аудитын төрөл, үйл ажиллагаанд иргэд хэрхэн оролцох талаар мэдээлэл өгөхөөр богино хэмжээний видео контентуудыг боловсруулан нийтэд хүргэв.



А.Батпүрэв

Иргэд улсын төсвийг хянах гарын авлага: Улсын төсвийн төлөвлөлтийн шатанд иргэд хэрхэн оролцож, хяналт тавих вэ?

Улсын төсвийн төлөвлөлтийн шатанд иргэд хэрхэн оролцож, хяналт тавих аргачлалын гарын авлагад иргэд хэзээ, хаанаас төсвийн мэдээлэл авч болох, яаж, ямар шалгуураар төсвийг шинжлэх, төсвийн төлөвлөлтийн шатанд хэрхэн оролцож, хяналт тавих аргачлалыг багтаав.

(<https://forum.mn/product/237210>)

ХЭВЛЭН НИЙТЛЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

1. Д.Төмөрпүрэв ахлагчтай баг. “Бүс Ба Зам” санаачилгын төслүүд дэх Монгол Улсын оролцоо, нөлөөллийн шинжилгээ (<https://forum.mn/product/233473>)
2. А.Батпүрэв. “Шинэ сэргэлтийн бодлого” хөтөлбөрт хийсэн хөндлөнгийн тойм дүгнэлт (<https://forum.mn/product/211533>)
3. С.Баттулгаар ахлуулсан баг. “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал” (<https://forum.mn/post/128389>)
4. Э.Цогбаяр. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө ба төсвийн уялдаа” (<https://forum.mn/post/128649>)
5. Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа 2021: Монгол Улсын үнэлгээний тойм (<https://forum.mn/product/241448>)
6. ННФ-ын дэргэдэх Төсвийн зөвлөл. Монгол Улс дахь инфляцын нөхцөл байдал болон дефолтын эрсдэл (<https://forum.mn/product/241438>)
7. ННФ-ын дэргэдэх Төсвийн зөвлөл. Монгол Улсын төсвийн төлөвлөлт (<https://forum.mn/product/237856>)
8. ННФ-ын дэргэдэх Төсвийн зөвлөл, “Байгалийн баялгийн засаглал” хөтөлбөр. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлд өгсөн санал (<https://forum.mn/product/211536>)
9. А.Батпүрэв. Иргэд улсын төсвийг хянах гарын авлага: Улсын төсвийн төлөвлөлтийн шатанд иргэд хэрхэн оролцож, хяналт тавих вэ? (<https://forum.mn/product/237210>)

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Байгалийн баялгаа хэр ухаалаг ашиглаж чадах эсэхээс Монгол Улсын иргэн бүрийн ирээдүйн хувь заяа шууд хамаарна.

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ

Байгалийн баялгаа тогтвортой хөгжлийн зарчмын дагуу урт хугацааны бодлогод тулгуурлан ашиглах, үр өгөөжийг тэгш шударга хуваарилах Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлээр эрдэс баялгийн салбарын засаглалын тулгамдсан асуудлуудаар бодлогын шинжилгээ хийж, хуулийн төслүүдийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулан санал шүүмжийг нэгтгэн бодлого боловсруулагчдад хүргүүлж, олон нийтийн хүртээл болголоо.

Олборлох салбарын ил тод байдлын тухай хууль

Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хуульчлахад чиглэсэн яриа хэлэлцүүлгийг түүштай өрнүүлснээр Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын баталгаажуулалтын мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Нээлттэй засаглалын түншлэл (НЗТ)-ийн Үндэсний IV төлөвлөгөөнд тусгалаа оллоо. Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)-аас УИХ-д өргөн барихад бэлтгэж буй хуулийн төсөлд төрийн бус байгууллагуудын саналыг нэгтгэн ОУИТБС-ын Олон улсын ажлын албаны санал шүүмжийг авч ХЗДХЯ-нд хүргүүлээ.

Газрын багц хуулийн төсөл

Газрын ерөнхий хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд үндэслэн газар чөлөөлөх тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай хуулиудыг багтаасан уг багц хуулийн төслийг орон нутгийн иргэд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал өгөх ажлыг Хүний эрх хөгжил төвтэй хамтран зохион байгуулав. Ийнхүү УИХ-аас уг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжин хэлэлцүүлэг өрнүүлж эхэлсэн боловч бэлчээрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, орон нутгийн иргэдийн эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх, тогтвортой хөгжлийн зорилт, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх бодлого, хөтөлбөртэй уялдуулах шаардлагын үүднээс Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) буцаан татаад байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл

Эрдэс баялгийн салбарт төрийн оролцоо нэмэгдэж байгаа энэ цаг үед төрийн өмчит компанийн засаглалыг олон улсын стандарт, сайн туршлагад үндэслэн боловсронгуй болгох шаардлага тулгамдаж байна. ННФ-аас “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл: Олон улсын туршлага ба Монгол Улс” судалгаанд үндэслэн компанийн зорилго, үйл ажиллагааны чиглэлээс хамааран төрийн өмчит компанийн ангилал, эрх зүйн статус, Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүн, тавих шаардлага, эрх үүргийг ялгамжтай тогтоох, бие даасан хараат бус байдлыг хангахтай холбоотой санал шүүмж боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлэв. Түүнчлэн төрийн өмч хөрөнгийг түүний зориулалт, мөн чанарт тулгуурлан зөв ангилах замаар түүнийг удирдах этгээдийн үүрэг хариуцлага, ялгаа заагийг оновчтой тодорхойлох, төрийн өмчийг бүртгэх, хянах, бусдад ашиглуулах, шилжүүлэх үндэслэл, арга зам, олон нийтийн хяналтыг сайжруулахад чиглэсэн саналыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөлд өгөв.

Ашигт малтмалын тухай хуулийн төсөл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-ны боловсруулж буй Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дүн шинжилгээ хийж, Үндсэн хуулиар тогтоосон тогтвортой хөгжил, хүний эрхийн зарчим, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх хүрээнд тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санал шүүмж хүргүүлээ. Тэрчлэн ашигт малтмалыг өмчлөх эрх, өмчлөл шилжих нөхцөл, газрын хэвлийн баялаг ашиглахтай холбоотой Засгийн газар болон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагын эрх мэдлийн хуваарилалт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба орон нутгийн иргэдийн оролцоо, эрдэс баялгийн салбараас эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийг бодитой тооцох замаар

салбарын цаашдын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг оновчтой тодорхойлох зэрэг асуудлаар сэдэвчилсэн судалгаа, дүн шинжилгээ хийж нийтийн хүртээл болголоо.

Эрх зүйн шинэчлэлтэй холбоотой судалгаа, санал шүүмж

- “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл: Олон улсын туршлага ба Монгол Улс” <https://forum.mn/product/211538>
- Хуулийн шүүмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл <https://forum.mn/product/211540>
- Хуулийн шүүмж: Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл <https://forum.mn/product/211511>
- Хуулийн шүүмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл <https://forum.mn/product/211535>
- Бодлогын асуудал №34. Ашигт малтмал өмчлөх эрх, түүний зохицуулалт <https://forum.mn/product/271740>
- Бодлогын асуудал №35. Уул уурхайн үйл ажиллагаа: Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба олон нийтийн оролцоо <https://forum.mn/product/272673>
- Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл <https://forum.mn/post/129478>

Уул уурхайн долоо хоног: “Сайн засаглал ба салбарын тогтвортой хөгжил” иргэний нийгмийн хэлэлцүүлэг

Ийнхүү эрдэс баялгийн салбарын цаашдын хөгжлийг тодорхойлох бодлогын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохын хамт бодлого боловсруулах үйл ажиллагааг нээлттэй болгоход анхаарч ажиллав. Тодруулбал, хууль, тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд хуулийг хэрэгжүүлэх буюу Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон олон нийтийн оролцоог хангах шаардлагатайг холбогдох талуудад сануулж ирлээ.

УУХҮЯ-аас 2022 оны 9 сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулсан “УУЛ УУРХАЙН 7 ХОНОГ” арга хэмжээний үеэр “Сайн засаглал ба салбарын тогтвортой хөгжил” сэдэвт иргэний нийгмийн хэлэлцүүлгийг

Төлсөн авсанаа нийтэл эвсэл, ОУИТБС-ын Ажлын албатай хамтран зохион байгуулж, эрдэс баялгийн салбарын шинэчлэлд Үндсэн хуулийн үзэл баримтлал, тогтвортой хөгжил, хүний эрхийн зарчмыг удирдлага болгон иргэдийн оролцоог хангахын чухлыг талуудад онцлон сануулсан юм. Салбарын бодлого, цаашдын хөгжлийг хэлэлцсэн тус арга хэмжээнд Өмнөговь аймгийн Хүрмэн, Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг, Дундговь аймгийн Баянжаргалан, Өлзийт сумдын төлөөллийг оролцуулж, уул уурхай бүхий орон нутгийн иргэдийн дуу хоолойг илэрхийлэх боломж олгосон нь уг арга хэмжээний онцлог байв. Учир нь тус салбарын хамгийн тулгамдсан асуудлын нэг болох орон нутгийн харилцааны асуудлыг эерэгээр шийдвэрлэхэд олон талын, тэр тусмаа орон нутгийнхны өөрсдийнх нь оролцоо амин чухал билээ.




Уул уурхайн 7 хоног, “Сайн засаглал ба салбарын тогтвортой хөгжил” салбар хуралдаан, 2022 оны 9 дүгээр сар.

АВИЛГЫН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХАД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд ил тод байдлыг үр дүнтэй ашиглах чиглэлээр төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авалтын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход анхаарч ажиллав. Энэ хүрээнд шилэн данс, худалдан авалт, эцсийн өмчлөгч, төрийн албан хаагчийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийн өгөгдлийн санг нэгтгэсэн хяналтын хэрэгсэл бүтээхэд Хөгжлийн төлөө өгөгдөл ТББ-тай хамтран ажиллаж байгаа билээ. ННФ-ын дэмжлэгтэйгээр 2021 хөгжүүлсэн тус өгөгдлийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэхэд энэ онд илүү анхаарч, төрийн өмчит

бүх уул уурхайн компанийн худалдан авалтын мэдээллээр өргөжүүлэхийн хамт өгөгдөл мэдээллээ тогтмол шинэчилдэг байх технологийн шийдлийг боловсруулж түршив. Тэрчлэн хэрэглэгчдэд хялбар болгох үүднээс мэдлэгийн граф технологийг ашиглан түүхий өгөгдлийг задлан шинжилж, хооронд нь холбох замаар гол баримт, мессежийг олж дүрслэн харуулах цахим хуудсыг бүтээлээ. Ингэснээр төрийн худалдан авалтад оролцсон хуулийн этгээдүүдийн өмчлөлийн хэлхээ холбоо, нийтийн албан хаагчдын хамаарал, шалгарсан тендер, түүний мэдээллүүдийг шууд зураглан харах боломж бүрдэх юм.



<http://graph.datastory.mn/dashboard>-д байршуулсан хяналтын хэрэгслийг ашиглан хуулийн этгээдийн хамаарал, эцсийн өмчлөгчийг өгөгдлийн сангаас шүүж, дүрслэн харуулж буй байдал


Хөгжлийн төлөө өгөгдөл ТББ нь нээлттэй өгөгдлийг ашиглан төрийн худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг олон нийтэд үлгэрлэн харуулах зорилгоор Open Extractives олон улсын байгууллага, Press Hub Mongolia ТББ-тай хамтран сэтгүүлчдэд зориулсан үе шаттай сургалт, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн менторшип хөтөлбөр хэрэгжүүлж, 20 гаруй сэтгүүлчийг хамруулав. Нийт 5 сар гаруй хугацаанд үргэлжилсэн энэхүү эрчимжүүлсэн хөтөлбөрөөр сэтгүүлчид төрийн өмчит компанийн онцлог, засаглалын тулгамдсан асуудлаас эхлээд худалдан авалт дахь авлигын эрсдэл, өгөгдлийн шинжилгээ, эрэн сурвалжлах сэтгүүл зүй,

олон улс болон дотоод дахь мэдээллийн эх сурвалжийг ашиглах зэрэг мэдлэг, үр чадвар эзэмшиж, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээлүүдийг түүрвиж эхлээд байна. Өгөгдлийн шинжилгээнд суурилсан эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээлүүд дээр Open Extractives байгууллагын өгөгдлийн шинжилгээ, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн менторууд болон үндэсний зөвлөх мэргэжилтнүүд санал зөвлөгөө өгч ажилласан юм. Дээрх хөтөлбөрийн хүрээнд түүрвисан эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээлүүдийг <https://dataclub.medium.com/> цахим хуудаснаас бүрэн эхээр нь авч сонирхоно уу.



Онцгой дэглэмийн онц ач холбогдолгүй худалдан авалт

Манай улсын хамгийн том татвар төлөгчдийн нэг болох Эрдэнэт үйлдвэрийн худалдан авалтын мэдээллийг сэтгүүлчийн дурангаар томруулан харж, 2019 онд тус үйлдвэрт онцгой дэглэм тогтоосноос хойш худалдан авалтын хэмжээ, үргүй зардал нь хэрхэн эрс нэмэгдсэнийг өгөгдлийн шинжилгээгээр нотолжээ. Энэхүү нийтлэл нь төрийн өмчит компаниудын худалдан авалтын төлөвлөлтийг сайжруулж, олон нийтийн хяналтад оруулснаар үргүй зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтойг бидэнд сануулж байна.



Тэнцүү олгосон нэртэй С зөвшөөрлийн ард Сингапур, Хятад ноёд туйлж байна

Энэхүү нийтлэлээр сэтгүүлчид сүүлийн үед дуулиан тариад буй нүүрсний экспорт, тээврийн асуудал руу лавхан өнгийжээ. Засгийн газраас нүүрс тээврийн үйл ажиллагаанд тэгш байдлыг хангаж, С зөвшөөрлийг хувиар тэнцүүлсэн журмаар олгож эхэлсэн билээ. Тэгвэл өнгөрсөн хугацаанд Эрдэнэс Тавантолгой ХК-ниас 188 компанид хувиар тэнцүүлсэн журмаар олгосон гэх 4000 гаруй зөвшөөрлийн 30-40 орчим хувийг хоорондоо хамаарал бүхий 2-3 компани авсан болохыг нээлттэй өгөгдөл харуулж байна.

Ийнхүү нээлттэй өгөгдлийг олборлож, засаглалын чухал асуудлуудыг баримттайгаар сөхөн хэлэлцүүлэх зорилго бүхий энэхүү ажилд тулгарсан гол бэрхшээл нь төрийн байгууллагуудын нээлттэй гэх мэдээллийн нээлттэй бус байдал байв. Төрийн байгууллагуудын мэдээлэл нь нээлттэй мэдээллийн стандартад нийцээгүй буюу алдаа ихтэй, татан авах, машинаар унших боломжгүй, хоорондоо уялдаа холбоогүй байгаа нь нийтийн баялагт тавих олон нийтийн хяналтыг сулруулж байна. Иймд нээлттэй мэдээллийн стандартыг нэвтрүүлэх, энэ чиглэлээр төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор "Төрийн нээлттэй өгөгдлийн давуу ба сул тал: Сайжруулах боломж" сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 3 дугаар сард зохион байгуулав. Цахим хөгжил,

харилцаа холбооны яам, Сангийн яам, УУХҮЯ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, төрийн өмчит уул уурхайн компаниудын төлөөлөл оролцсон уг хэлэлцүүлгээр төрийн өмчит уул уурхайн компанийн худалдан авалт, борлуулалтын мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн туршлага, сургамжид үндэслэн нээлттэй өгөгдлийг ашиглахад тулгарч буй бэрхшээл, цаашид сайжруулах боломжийг хэлэлцэв. Ингэснээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой стандарт журмуудыг боловсруулах ажлын хэсэгт Хөгжлийн төлөө өгөгдөл ТББ-ын зөвлөх мэргэжилтнүүд орж ажиллаа.



Дорноговь аймгийн Айраг сумын Нард багийн иргэд, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хэрхэн оролцох талаар суралцаж байгаа нь

НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ НЭХЭМЖЛЭН ХАМГААЛАХ

ННФ нь иргэний хяналтын чухал хэрэгсэл болох нийтийн эрх ашгийн өмгөөллийг түгээн дэлгэрүүлэхэд анхаарч, энэ чиглэлээрх иргэний нийгмийн байгууллагуудын санаачилга, үйл ажиллагааг дэмжин чадавх бэхжүүлэх ажлыг түүштай хэрэгжүүлж ирсэн билээ. Нийтийн ашиг сонирхлыг шүүхээр хамгаалахад тулгарч байгаа бэрхшээлийг арилгах зорилгоор Монголын хуульчдын холбооны захиргааны эрх зүйн хороо, Эмнести Интернэшнл ТББ-тай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, олон дахин буцаах, төрийн бус байгууллагын нэхэмжлэх эрхийг тогтооход харилцан адилгүй жишиг баримтлах, хэрэгт ач холбогдолгүй нотлох баримт шаардах, нэхэмжлэгч нарт учирч буй дарамт шахалт зэрэг нийтийн эрх ашгийн өмгөөлөлд тулгардаг нийтлэг бэрхшээлүүдийн шийдлийг хэлэлцэн зөвлөмж гаргав.

Энэ чиглэлээр 2016-2021 онд олгосон 41 тэтгэлгийн хүрээнд 49 өмгөөлөл явагдсанаас 22 нь эцэслэн шийдвэрлэгдээд байна. Үүнээс эрдэс баялгийн

салбарт холбогдох 15 хэрэгт нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь болон зарим хэсгийг хангах шийдвэр гарчээ. ННФ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд захиргааны хэргийн шүүх болон төрийн холбогдох байгууллагуудаас нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдол бүхий дараах шийдвэрүүдийг энэ онд гаргажээ.

- Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ-ын нэхэмжлэлтэй Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын мэдээллийг нүүцэлсэн БОАЖЯ-ны хууль бус үйлдлийг тогтоолгох хэргийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж, тусгай хамгаалалттай газарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөл, газар ашиглах гэрээний дугаар, хугацаа, газар ашигласны төлбөрийн мэдээллийг ил тод болгохыг БОАЖЯ-нд яаманд даалгав.
- Их бага Баяншарга ТББ Дундговь аймагт олгогдсон тусгай зөвшөөрлүүдийг цуцлуулах нэхэмжлэлийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд гаргаад

байна. Тус байгууллага өмнө нь Сүхбаатар аймагт олгогдсон цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хууль бусд тооцуулах өмгөөллийг амжилттай хэрэгжүүлсэн билээ. Гэвч Дундговь аймагт холбогдох хэргийн хувьд гуравдагч этгээдээр хэрэгт оролцож буй компанийн зүгээс удаа дараа үндэслэлгүй гомдол гаргаж, төрийн байгууллагууд түүнийг нь шалган шийдвэрлэхдээ удаан хугацаа зарцуулж байгаагаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч, нэхэмжлэгчийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах дарамт шахалтууд үүсээд байна. Энэ бол нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалж буй иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийг хамгаалагчдад тулгарч байгаа нийтлэг бэрхшээл болохын хувьд 2021 онд батлагдсан Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн эрчимжүүлэх нь нэн чухал байна.

- Хил хязгааргүй алхам ТББ-аас хэрэгжүүлсэн өмгөөллийн үр дүнд Дорноговь аймаг 2022 онд тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулахдаа Захиргааны

ерөнхий хуулийн дагуу Сонсох ажиллагаа хийжээ. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуульд орон нутгийн гэрээ байгуулахад олон нийтийн хэлэлцүүлэг явуулах заалт тусгаад байна.

- Тус байгууллага нь Таван толгойн бүлэг ордоос хийгдэж буй нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд Засгийн газрын 2018 оны 276 дугаар тогтоолын хэрэгжилтийг шаардсанаар Их газрын чулууны улсын тусгай хамгаалалттай газраар тээвэр хийхийг зогсоов. Засгийн газрын дээрх тогтоолоор уул уурхайн тээврийг шороон замаар хүнд даацын тээврийн хэрэгслээр хийхийг хориглосон байдаг юм.
- Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхим Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын зарим заалтыг Усны тухай хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болголоо. Үүний дагуу УУХҮЯ дээрх журамд нэмэлт өөрчлөлт оруулж, тусгай зөвшөөрөл олгоход усны сав газраас санал авах зохицуулалт тусгав. Ингэснээр 10 гаруй жилийн турш хэрэгжихгүй явж



ирсэн Усны тухай хуулийн шаардлага уул уурхайн салбарт хэрэгжих нөхцөл бүрдэв.

- Засгийн газрын 2023 оны 02 сарын 08-ны өдрийн хуралдаанаар “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх журам” батлагдав. Хил хязгааргүй алхам ТББ нь уул уурхайн төслийн нөлөөлөлд өртөж хохирсон Дорноговь аймгийн Айраг сумын Нард багийн 12 малчин өрхөд нөхөн төлбөр олгуулах зорилго тавьсан боловч учирсан хохирлыг тооцох, нөхөн төлбөр олгох журам, аргачлал байхгүйгээс анх тавьсан зорилгодоо хүрэхэд хүндрэл үүсээд байв. Иймд хөдөө орон нутгийн иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах тогтолцоо бүрдүүлэх үүднээс нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх, нөхөн төлбөр тооцох журам батлуулахаар ажиллаж байна.
- Хонгор нутгийн дуудлага ТББ нь Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст суманд хэрэгжүүлж буй алтны үндсэн орд ашиглах төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын

үнэлгээг хууль бусад тооцуулахаар шүүхэд хандаад байна. Говийн их дархан цаазат газартай залгаа уг газарт тархан амьдардаг мазаалай, хар сүүлт, хавтгай бөхөн зэрэг нэн ховор амьтад болон сүхай, тоорой зэрэг нэн ховор ургамлыг хамгаалах асуудлыг үнэлгээний тайланд бүрэн тусгаагүй, багийн иргэдийн Нийтийн хурлын саналыг зохих ёсоор аваагүй нь ийнхүү гомдол гаргах үндэслэл болсон юм.

- Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо ТББ нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг шаардан ажилласнаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсөвт энэ чиглэлийн зардлыг тусгуулжээ. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яам харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан бичгэн мэдээллийг ярианд хөрвүүлэх программ хөгжүүлж эхэлжээ.

- Ховдын толь ТББ нь Ховд аймгаас МонЭнКо ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2022 оны хэлэлцээрт оролцож, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих багт иргэд, ялангуяа төслийн нөлөөлөлд өртөх сумдын иргэдийн төлөөллийг оролцуулах, гэрээний хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх, Ховд Хөшөөт хөгжил сангийн зарцуулалтыг иргэдэд тайлагнах зэрэг заалтуудыг тусгуулжээ. Тэрчлэн тус байгууллага нь Цагаан эргийн улсын тусгай хамгаалалттай газарт учирсан байгаль орчны хохирлыг нөхөн төлүүлэх, хамтын ажиллагааны гэрээ байгуулах үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа уул уурхайн компаниудад хариуцлага тооцуулах, газрын ховор элементийн орд ашиглах үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлд өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагаа явуулж байна.

- Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн ТББ нь газрын тосны салбарт хариуцлагыг бэхжүүлэхэд анхаарч, Халхгол, Матад сумдын Засаг даргыг төлөөлөн нэхэмжлэл гаргаснаар шүүхээс Петрожайна Дачин Тамсаг ХХК-д Газрын тосны тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж орон нутагтай гэрээ байгуулах, өмнөх жилийн гэрээний дагуу хийх ёстой хөрөнгө оруулалтыг сумдын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхийг даалгах шийдвэр гаргажээ. Шүүхийн шийдвэрийн дагуу Матад суманд 2.6 тэрбум, Халхгол суманд 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх юм. Харин ийнхүү суманд хийгдэж буй хөрөнгө оруулалтыг иргэдийнхээ хараа хяналт дор үр ашигтай, хариуцлагатайгаар зарцуулах, энэ чиглэлээр иргэдийг идэвхжүүлэн сургахад анхаарах шаардлагатай нь харагдаж байгаа юм.





САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2022 онд нийт 6,481,045 мян.төгрөгийн санхүүжилтийн орлоготой ажилласан ба үүнээс 6,173,931 мян.төгрөг нь Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон түүний сүлжээний хөтөлбөрүүд, 307,114 мян.төгрөг нь бусад донор байгууллага болон өөрийн санхүүжилтийн орлогоос санхүүжигдсэн болно. Санхүүжилтийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

мянган төгрөг

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ			
Ардчиллын институцийг бэхжүүлэх нь	849,119	483,893	1,333,012
Иргэний оролцоог дэмжих нь	239,621	505,156	744,777
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО			
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	166,062	639,236	805,298
Хүний эрх	119,075	195,771	314,846
Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг дэмжих нь	23,889	385,141	409,030
НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ			
Төсвийн хариуцлагыг сайжруулах нь	136,147	541,361	677,508
Эрдэс баялгийн салбарт сайн засаглалыг дэмжих нь	147,726	460,455	608,181
			-
ЗАХИРГАА		1,039,434	1,039,434
			-
НИЙТ ДҮН	1,681,640	4,250,448	5,932,088

2022 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ (ХӨТӨЛБӨРӨӨР)

Хөтөлбөр	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт тэтгэлгийн зардал
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ			
Ардчиллын институцийг бэхжүүлэх нь	893,340	-	893,340
Иргэний оролцоог дэмжих нь	272,757	-	272,757
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ БОДЛОГО			
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	145,070	39,843	184,913
Хүний эрх	119	-	119
Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг дэмжих нь	152,329	29,897	182,226
НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ			
Төсвийн хариуцлагыг сайжруулах нь	154,105	-	154,105
Эрдэс баялгийн салбарт сайн засаглалыг дэмжих нь	157,913	-	157,913
Хаагдсан тэтгэлгүүд	(115,915)	(47,819)	(163,734)
НИЙТ ДҮН	1,659,718	21,921	1,681,640

2022 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ (БАЙГУУЛЛАГААР)

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Байгууллагын төрөл	Тэтгэлгийн дүн
1	Улаанбаатар	Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн паралегалууд	ТББ	600
2	Улаанбаатар	Баярмаа Батсүх	Эрүүгийн эрх зүйн хүрээнд бага хуралд оролцох	Иргэн	789
3	Улаанбаатар	Үнэнбат Маамба	Эрүүгийн эрх зүйн хүрээнд бага хуралд оролцох	Иргэн	789
4	Улаанбаатар	Монголын эмнести интернэшнл ТББ	Хүний эрхийн сан	ТББ	90,000
5	Улаанбаатар	Цэцгээ Гомбодорж	Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх	Иргэн	123
6	Улаанбаатар	Давааням Ганхуяг	Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2018 оны 04 сарын 17, № 001/ХТ2018/00617 тогтоолд дүн шинжилгээ хийх	Иргэн	2,430
7	Улаанбаатар	Түвшинтөгс Адъяасүрэн	Иргэний хуулийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д буй Бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн тохиолдолд бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцож буй шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа	Иргэн	6,000
8	Улаанбаатар	Тунгаахуй өгөгдлийн урлан ХХК	“Нээлттэй өгөгдөлд суурилсан нээлттэй засаглалыг бэхжүүлэх нь”	ХХК	28,320
9	Улаанбаатар	Цогц хөгжлийн үндэсний төв ТББ	“Нийтийн сонсгол-нээлттэй парламент”	ТББ	30,324
10	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт НҮТББ	“Улс төрийн санхүүжилт ба сонгууль”	ТББ	122,760
11	Улаанбаатар	ЭССТ НҮТББ (эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв)	9 дэх удаагийн “Global factcheckin summit” аялалын тэтгэлэг	ТББ	9,610

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Байгууллагын төрөл	Тэтгэлгийн дүн
12	Улаанбаатар	Хөгжлийн төлөө өгөгдөл ТББ	Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авалтын өгөгдлийн санг хэрэглээнд нэвтрүүлэх нь	ТББ	105,406
13	Улаанбаатар	Ганхүрэл Дамба	Амьтны учруулсан гэм хорыг арилгуулахтай холбогдох шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	Иргэн	8,938
14	Улаанбаатар	Намуун Пүрэвжал	Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийх дүн шинжилгээ	Иргэн	3,900
15	Улаанбаатар	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн	Шүүхийн сахилгын хорооны сахилгын хэрэг хянан шийдвэрлэж буй процесс, шийдвэрт хийсэн дүн шинжилгээ	Төрийн байгууллага	10,000
16	Улаанбаатар	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сонсголгүй хүмүүст нээлттэй болгох	ТББ	21,350
17	Улаанбаатар	Оюуны инноваци ГҮТББ	Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газарт өмгөөлөгчид саадгүй нэвтрэх боломжийг олгох	ТББ	12,023
18	Улаанбаатар	Баянжаргал Чадраабал	Өв залгамжлал, гэрээслэлтэй холбоотой иргэний хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн харьцуулсан судалгаа	Иргэн	8,000
19	Улаанбаатар	Хөх-ах НҮТББ	Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдэд хяналт тавих	ТББ	12,000
20	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт НҮТББ	Орон нутгийн төсвийн хяналтын чадавхийг бэхжүүлэх	ТББ	40,488
21	Улаанбаатар	Галсанбат Бурмаа	9-р сард АНУ-д суралцах аялал	Иргэн	14,159
22	Улаанбаатар	Нарангэрэл Гонгорбаатар	9-р сард АНУ-д суралцах аялал	Иргэн	14,159
23	Улаанбаатар	Монголын дауны холбоо НҮТББ	“Бид чадна, бид авъяастай” төслийн 2 дахь циклийн хүрээнд “Бүжигчин” богино хэмжээний кино бүтээхэд Монголын Дуаны Холбоог оролцоог дэмжих	ТББ	13,159

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Байгууллагын төрөл	Тэтгэлгийн дүн
24	Улаанбаатар	Хэрэглэгч сан	Засаг дарга нарын нөөцийн сангийн зарцуулалтад шинжилгээ хийх	ТББ	7,398
25	Улаанбаатар	ЭССТ НҮТББ (эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв)	Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хяналт	ТББ	3,450
26	Улаанбаатар	П.Намуун баг	Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөг гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийх дүн шинжилгээ	Баг	7,500
27	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	Байгаль орчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн өмгөөлөл	ТББ	33,350
28	Улаанбаатар	Хууль дээдлэх ёс ТББ	Хулгайн гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн практик	ТББ	5,525
29	Улаанбаатар	Онч шийдэл	Төрийн захиргааны байгууллагын эс үйлдлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх	ТББ	8,945
30	Улаанбаатар	Ө.Болортуяа баг	Маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж, шинэ акт гаргахыг хариуцагчид даалгаж шийдвэрлэсэн захиргааны шүүхийн шийдвэрийн судалгаа	Баг	2,952
31	Улаанбаатар	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төв	Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа	ТББ	7,260
32	Улаанбаатар	Хүний эрх хөгжил төв	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн өмгөөлөл	ТББ	19,156
33	Улаанбаатар	Цогц хөгжлийн үндэсний төв	Нээлттэй парламент	ТББ	107,528
34	Улаанбаатар	Монголын залуучуудын эвсэл ТББ	9 дүүргийн төсвийн зарцуулалтын хяналт	ТББ	86,960
35	Улаанбаатар	Тогтвортой хөгжлийн төлөөх сэтгүүл зүй	Орон нутгийн төсөвт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, , сэтгүүлчдийн чадавхыг нэмэгдүүлэх нь	ТББ	56,900

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Байгууллагын төрөл	Тэтгэлгийн дүн
36	Улаанбаатар	ЭССТ НҮТББ (эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв)	Залуу сэтгүүлчид, орон нутгийн сэтгүүлчид болон реакцид баримт нягтлан шалгах (fact-checking) мэргэжлийн ур чадвар олгох, сонгогчид болон олон нийтийн мэдээллийн боловсролыг дэмжих хөтөлбөр	ТББ	82,250
37	Улаанбаатар	Түгээмэл хөгжил ТББ	MAKS програмын алдагдсан өгөгдлийг сэргээх	ТББ	600
38	Улаанбаатар	Глоб интернэшнл төв ТББ	Монгол кино ба Хүний эрх	ТББ	29,075
39	Улаанбаатар	Бодлогын инновацийн хүрээлэн	“Бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал ба залуусын оролцоо” ази, номхон далайн орнуудын залуучуудын форум	ТББ	63,000
40	Улаанбаатар	Тунгаахуй өгөгдлийн урлан ХХК	“Нээлттэй өгөгдөлд суурилсан нээлттэй засаглалыг бэхжүүлэх нь II”	ХХК	90,498
41	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт НҮТББ	“Нийтийн мэдээллийн ил тод байдал, сонгуулийн хяналтыг бэхжүүлэх замаар хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэх нь”	ТББ	221,618
42	Улаанбаатар	Глоб интернэшнл төв ТББ	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэлтэй байх, улс төрийн үйл явцад мэдээлэлтэй оролцох эрх	ТББ	150,540
43	Улаанбаатар	Оюуны инноваци ГҮТББ	Байгууллагын тогтвортой байдлыг дэмжих	ТББ	120,000
44	Улаанбаатар	Стратеги судалгааны хүрээлэн	Бүс нутгийн энх тайван, тогтвортой байдалд залуусын оролцоог дэмжих	Төрийн байгууллага	65,692
45	Улаанбаатар	Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төв	Олон нийтийн мэдээллийн боловсролыг дэмжих, мэдээллийн чанарыг сайжруулах	ТББ	51,040
46	Улаанбаатар	Хил хязгааргүй хуульчид НҮТББ	Оюутны өмгөөлөл, нөлөөлөл-2023	ТББ	68,808
Хаагдсан тэтгэлгүүд					(163,734)
НИЙТ ДҮН					1,681,640

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

Удирдах Зөвлөлийн гишүүд

О.Мөнхсайхан	Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн ХЗС-ийн профессор, Хууль зүйн доктор
Ж.Үнэнбат	Удирдах зөвлөлийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын зөвлөх
П.Наранбаяр	Удирдах зөвлөлийн гишүүн, Сайн сургуулийг таны дэргэд ТББ-ын тэргүүн
Д.Энхжаргал	Удирдах зөвлөлийн гишүүн, МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний Ерөнхий зохицуулагч
Ч.Болортуяа	Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхий сайдын зөвлөх

Гүйцэтгэх захирал

П. Эрдэнэжаргал

Ажилтнууд

П.Бадамрагчаа	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
А.Гэрэлмаа	Иргэний оролцооны хөтөлбөрийн менежер
Д.Оюунбадам	Засаглалын хөтөлбөрийн менежер
Б.Хишигсайхан	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
Д.Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
Д.Эрдэнэчимэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
О.Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан
Б.Ундармаа	Хөтөлбөрийн туслах ажилтан
Б.Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан
Д.Балжид	Мэдээллийн менежер
Б.Мөнхгэрэл	Мэдээллийн ажилтан
Д.Жавхлан	Захиргаа, Санхүүгийн захирал
Ж.Алтанчимэг	Тэтгэлгийн менежер
В.Халиунцэцэг	Нягтлан бодогч
Э.Сайнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч
Б.Амгалан	Захиргааны ажилтан
Б.Баатар	Захиргааны туслах ажилтан
Г.Цэдэвхүү	Захиргааны туслах ажилтан
Б.Бат-Эвлэл	Захиргааны туслах ажилтан

Нийтлэг И-мэйл: osf@forum.mn

